

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	0
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-32
<hr/>	
<b>1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар тогтоолтой холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал</b>	4-9
<b>2. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт /Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/</b>	9-29
<b>3. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</b>	29-33

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 24-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, У.Отгонбаяр, Ц.Сандаг-Очир;  
Чөлөөтэй: Х.Баттулга, Л.Мөнхбаатар, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, С.Одонтуяа, Да.Цогтбаатар.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар тогтоолтой холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар тогтоолыг танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар тогтоолтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Энхбаяр, Д.Ганбат, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

**Д.Цогтбаатар:** Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтад зохих найруулгын шинжтэй өөрчлөлтийг оруулан хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт /Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга Ц.Тогосмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Энхбаяр, Д.Ганбат, Д.Цогтбаатар, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга Ц.Тогосмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Сайнзориг, Б.Энхбаяр, С.Эрдэнэболд, Б.Заяабал, Д.Ганбат, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

**Д.Цогтбаатар:** Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаандаа зөрчлөө арилгаагүй 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

**Д.Цогтбаатар:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 50 минут минут үргэлжилж, 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 11 цаг 10 минут

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдааны ирц Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр, С.Эрдэнэболд гэсэн ийм ирцтэйгээр манай Байнгын хорооны хурлын ирц бүрдсэн байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал байгаа.

1 дэх асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар тогтоолтой холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт /Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудал/

3 дугаар асуудал. Байнгын хорооны тогтоол /Ажлын хэсэг байгуулах тухай/ ийм тогтоол байгаа. Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Байхгүй байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дүгээр асуудал.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар тогтоолтой холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцье.**

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар тогтоолыг гишүүдэд бол тараасан байгаа.

Хууль зүйн байнгын хорооны зүгээс танилцуулгыг би уншиж танилцуулна.

Монгол Улсын иргэн Ч.Анар, Ш.Эрбол нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтад Цагдаагийн алба хаагчид үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг сурталчлах, дэмжлэг үзүүлэхийг хориглосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтад нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл

бодлын үүднээс олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй гэснийг зөрчсөн эсэхийг хянан хэлэлцэж өгнө үү гэсэн агуулга бүхий мэдээлэл, гомдлыг ирүүлсэн байдаг.

Улмаар дээрх асуудлаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэж 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцээд Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт цагдаагийн албан хаагчид дараах зүйлийг хориглоно гээд 69.1.8 дахь заалтад Нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүн дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх гэж заасны үйлдвэрчний эвлэлийн гэсэн нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтын нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхлын үүднээс олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийг Улсын Их Хуралд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурал 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 5 дугаар сарын 22-ны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэн Улсын Их Хурлын 60 дугаар тогтоолыг баталсан.

2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаанаар Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийн тухай 60 дугаар тогтоолыг хянан хэлэлцээд Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар тогтоолыг баталсан байна.

Тус тогтоолын тогтоох хэсэгт:

Нэг.Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт цагдаагийн албан хаагчид дараах зүйлийг хориглоно гээд 69.1.8 дахь заалтад нам, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг нам, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх гэж заасныг үйлдвэрчний эвлэлийн гэсэн нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь заалтын нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхлын үүднээс олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй гэснийг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 2 дугаар дүгнэлтийн тухай 60 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

Гурав.Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай гэж заасан байгаа юм.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцууллаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Шууд асуулт, үг хэлэх хоёроо хамт явуулчихъя. Энхбаяр, Сайнзориг, Ганбат гишүүнийг би орууллаа. Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Одоо тэгээд Цэцийн эцсийн шийдвэр гарчихсан учраас одоо ямар ч арга алга. Ер нь бол яах вэ зүгээр бодолцож үзэх л ёстой байсан болов уу. Ер нь зүгээр хууль сахиулах, батлан хамгаалах гэдэг юм уу ийм чиглэлийн байгууллага дээр ингээд үйлдвэрчний эвлэл гэдэг юм уу ийм зүйл яриад эхлэх юм бол бас хэр зохимжтой байдаг байгаа юм. Зүгээр зарим зүйл яах вэ зүгээр Цэцийн шийдвэрүүдийн гарч байгаа тэр судалж байгаа юу энэ тэр зөв боловч эцсийн шийдвэр дээр үнэхээр асуудалтай шийдвэр гаргаж байна. Бид бас өмнө нь Цагдаагийн хуулийн авахдаа тэр баривчлах асуудлыг зөвхөн одоо юу гэдэг юм агуулгыг нь өргөжүүлээд өгчих юм дээр Үндсэн хууль зөрчсөн гээд. Тэгээд Үндсэн хууль зөрчсөн агуулгыг сэргээгээд л яваад байгаа юм. Сэргээгээд л яваад байгаа юм. Тэгээд энийгээ ч бид хүлээгээд авчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг иймэрхүү зүйлүүд дээр харамсалтай байна. Би зүгээр яах вэ тухайлан энэ хууль дээр гэхээсээ илүүтэйгээр ер нь зүгээр Хууль зүйн байнгын хорооноос бас энэ цэцийн хууль, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийнхаа шинэчилсэн найруулгыг боловсруулж байгаа ажлын хэсгээ жоохон шуурхайлъя.

2 дугаарт цэцийн шийдвэрийг гарсны дараа Улсын Их Хурал бол хүлээгээд авчгаж болно. Авчхаад жоохон хугацаатай бас хуулийн төслийг боловсруулж баймаар юм дарга аа. Энэ яах вэ зүгээр хялбархан. Гэтэл том том шийдвэрүүд гаргадаг хэдэн хувилбараар бодох магадгүй наад захын бас нэг салбарын хүмүүс дээр нэг хэлэлцүүлэг хийх ч гэдэг юм уу ийм зүйл байхгүй болохоор цэц тэнд шийдвэрээ гаргачхаад, дүгнэлтээ бичихдээ хугацаа авч болдог, Улсын Их Хурал болохоор ерөөсөө гялалзуулаад л хийхээс өөр арга байхгүй. Оруулж байгаа хувилбарууд нь сүүлдээ асуудал тарьчих гээд байгаа юм. Тэгэхээр бид хэд эдгээр хуулиудаа хурдан сайжруулаад, мэдээж цэцийн шийдвэрийг гаргаж байгааг хүндэтгэж байгаа. Тэгээд авахдаа бид нар бас бодолцоод хийе. Би энэ дээр бол юм ярихгүй. Ер нь зүгээр нэлээн бодож хийх.

Дараагийн асуудал бол энэ татварын асуудлууд байгаа. Энэ дээр магадгүй ямар шийдвэр гарахыг мэдэхгүй байна. Тэгэхдээ ер нь зүгээр цаашдаа хууль тогтоомжийн хуульд Цэцийн эцсийн шийдвэр гараад ч юм уу эсвэл хүлээж аваад орууллаа гэхэд тэр дор нь оруулна гэдэг юм бас их хэцүү байхгүй юу. Энэ чинь маш олон уршигтай бас бодож хийх юмнууд байгаа. Тэгэхээр ер нь бид хэд бас энийг зүгээр хууль тогтоомжоо хурдан шуурхай цэгцлэх талд нь л анхааръя. Тэгээд ер нь бас бичилт энэ тэр дээр нь зузаараад байгаа боловч яг эцсийн тэр гаргаж байгаа шийдвэрүүд бол их болчимгүй байгаа гэдэг зүйлийг би одоо хэлмээр байна. Цэцийн хувьд.

**Д.Цогтбаатар:** Сайнзориг гишүүний хэлснийг манай Байнгын хорооны ажлын алба тэмдэглээд аваарай. Энэ Үндсэн хуулийн цэцийн талаарх хууль тогтоомжид бид нар бас судалгаа, дүгнэлт хийж үзэх ёстой. Тэрийгээ та нар ажлаа яаравчлаарай гэж байна. Тэрийгээ манай ажлын алба тэмдэглээд аваарай. Энхбаяр гишүүнд микрофон өгье.

**Б.Энхбаяр:** Цагдаагийн албан хаагч үйлдвэрчний эвлэлийн гишүүн байхыг хязгаарласан энэ заалт бол Монгол Улсын Үндсэн хуулийн эвлэлдэн нэгдэх эрхийг

зөрчсөн байна гэсэн Цэцийн шийдвэр эцэслэж гарсан байна. Мэдээж энэ Цэцийн эцсийн шийдвэрт бол хүндэтгэлтэй хандаж байгаа. Үүнтэй холбоотойгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох бас үүрэг хууль тогтоогч хүлээж таарна. Энэ хүрээндээ Монголын үйлдвэрчний эвлэлийн тухай хуулийг авч үзэхэд энэ асуудлыг бас дахин хөндөх, ярих ёстой гэж бодож байгаа.

Үндсэн хуулийн цэц бол саяхан бас нэг шийдвэр гаргачихсан. Тэр нь Монгол Улсын шинэ Үндсэн хуулиас өмнө батлагдсан хууль тогтоомжууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц авч үзнэ гэдэг ийм шийдвэр гаргачихсан байгаа. Энэ дотор 1991 онд байгуулагдсан БНМАУ-ын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны тухай хууль өөрөө Үндсэн хуульд ер нь зөрчиж байгаа юм уу, үгүй юу гэдгийг бас ярих ёстой. Одоо энэ яг социализмын үеэрээ үлдчихээд байгаа хэдхэн газрын нэг нь энэ үйлдвэрчний эвлэл байгаа. Ер нь яг энэ үйлдвэрчний эвлэл чинь өөрөө ямар сонирхолтой вэ гэхээр хөдөлмөрчин ангийн эрх ашиг сонирхлыг хамгаална гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ анги давхаргаар ялгадаг энэ юм маань ер нь ямар учиртай юм бэ гэдгийг авч үзэх ёстой. Үүний хөрөнгө мөнгө нь ямар байдаг юм. Наад захын төр шилэн данстай болчихоод байхад үйлдвэрчний эвлэлийн хөрөнгө, санхүү нь яасан нь мэдэгдэхгүй. Замын цагдаагийн тэнд байсан газрыг зарсан гэдэг нь Хөгжлийн банкны сонсголын үеэр гарч ирсэн. Тэр үйлдвэрчний эвлэлийн аж ахуйн дарга нь өөрөө Улсын Их Хурлын гишүүний эхнэртэй хамааралтай компанитай гэдэг нь нотлогдсон. Тэр гишүүн тэр үйлдвэрчний эвлэлийн газрыг зарж Их Хуралд орж ирсэн гэдэг асуудал олны ам бол ортой юм байна гэж би л лав ойлгосон. Жишээлбэл. Энэ үйлдвэрчний эвлэлийн нэрийг барьж улс төр хийдэг, эрх ашгийг нь яадаг энэ асуудлыг их авч үзэх ёстой юм байна лээ. Яагаад гэхээр Америкийн Нью-Йоркийн мафиийг Холбооны мөрдөх товчоо бол 1900 чинь хэдэн онд билээ. 80-аад онд байх. 1980-аад онд тусгай ажиллагаа явуулж, таслан зогсоосон шүү дээ. Энд хамгийн том яригдсан асуудал бол Америкийн үйлдвэрчний эвлэлүүдийг Нью-Йоркийн мафи удирдаж байсан гэдгийг нотолсон шүү дээ. Өөрөөр хэлбэл мафиудын гар хөлөөр зориуд ажил хаялт зохион байгуулна шүү, цалин өсгөх, зогсооно шүү гэдэг байдлаар бүх бизнесийн салбаруудыг хэрэг дээрээ мафи үйлдвэрчний эвлэлээр дамжуулаад гартаа оруулчихсан байсан байхгүй юу.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр гишүүнд микрофон өгье.

**Б.Энхбаяр:** Тэгэхээр бид нар энэ үйлдвэрчний эвлэл гэдэг байгууллагын асуудлыг ганцхан эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний хүрээнээс гадна, үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, бизнесийн эрх ашиг, хууль ёсны рикетүүд ийм одоо гэмт зохион байгуулалттай бүлэглэл цаашдаа болохгүй байх талаас нь өмнөх энэ олон улсын түүхийн сургамжууд дээр бас үндэслэх ёстой байхгүй юу. Бидний ардчилсан хувьсгал, манай ардчилагчид бол коммунизм бол алдаа байсан гэж ойлгодог тийм үү та бүхэн маань. Тэгвэл коммунизмыг анх хувьсгал хийсэн тэр Октябрийн хувьсгал чинь хаана суурилж гарч ирсэн юм. Хөдөлмөрчин анги, ажилчин ангийн эрх ашиг, тэдний дуу хоолой гэж гарч ирээд коммунизм байгуулсан шүү дээ тоталитар дэглэмийг. Тэрний суурь нь үйлдвэрчин байхгүй юу. Тийм учраас энэ үйлдвэрчний эвлэлийн БНУ-ын үйлдвэрчний эвлэлийн өөрийнх нь хуулийг хууль тогтоогч бол даруй .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Ганбат гишүүнд микрофон өгье.



**Д.Ганбат:** Мэдээж хэрэг Цэцийн шийдвэр гарсан байна. Тэрийг хүлээж авах нь ойлгомжтой. Үгүй ээ, хүлээж авахгүй ч байсан л эцсийн шийдвэр бол тэгээд л явдаг юм байгаа биз дээ. Хууль нь тийм. Тэгээд энэ дээр бас жоохон нюансууд байна. Тухайлбал энэ хуулийг хүлээж авчхаад бид нар энэ хуулийг боловсронгуй болгосон нь зөв байх. Энэ цагдаагийнхаа хуулийг. Тийм боломж бол Улсын Их Хуралд байгаа. Энэ дээр бид нар ажиллавал яасан юм бэ. 2 талтай л юм л даа. Одоо Үндсэн хуульдаа бас эшилье. Үндсэн хуульд чинь хүн болгон л нөгөө улс эх орноо батлан хамгаалах үүрэгтэй, энэ тэр гээд заачихсан байгаа л даа. Иргэн хүний хүндэт үүрэг гээд заачихсан. Тэгээд тэр нь биелэгддэггүй. Тэр Цэц чинь энэ хүндэт үүргээ биелүүлсэн хэдэн хүн байдаг юм бэ. Байхгүй байгаа байхгүй юу. Манай Улсын Их Хурал ч гэсэн бас маш цөөхөн.

Тэгэхээр энэ цэрэг чинь арай өөр. Тангараг өргөдөг, вагон зүүдэг, тушаалаар, тушаалыг хэлэлцдэггүй ийм онцлогууд байгаа байхгүй юу. Цагдаа яг ижилхэн шүү дээ. Бас вагон зүүж байгаа. Тангараг өргөж байгаа. Тэгээд бид нар бас нэг буруу юм ойлгоод байх юм. Тэр байтугай цагдаагийн албан хаагч энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоно гээд байгаа байхгүй юу. Үгүй ээ, тэр ч цагдаа л бол цагдаа шүү дээ. Тэгээд яах юм. Бусад улс оронд энхийг сахиулах үйл ажиллагаа дотор үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн албан хаагч тэнд цагдаа чигээрээ л байна шүү дээ. Бусад улс орны нутаг дэвсгэр дээр бол цагдаагийн үйл ажиллагаа явуулахыг хориглодог ийм нэг гажуу гажуу юмнууд манай дээр байгаа байхгүй юу. Тэгээд энэ нь одоо байх ёстой юм шиг ингэж ойлгоод байдаг. Энэ нь яах вэ, бид нарын тэр юмыг яаж хүлээж авч байгаа ойлгож байгаа энэ бүх юмтай хамааралтай байна. Энийгээ үндсээр нь өөрчлөх цаг болсон юм шүү. Ийм л байх ёстой юм шиг ойлгоод байдаг. Нөгөө жишиг болсон олон улсын иргэншсэн нийгэмд байдаг энэ юмаа ингээд харьцуулаад аваад үзэхээр бол энэ арай болохгүй юм гэсэн ийм зүйл байдаг. Ер нь яагаад ийм зүйл гараад байна вэ гэхээр одоо бид нар нөгөө баахан мөнгө төгрөг тэр юун дээр тавьчихсан. Тэр камер дээр. Тэр камерыг ашиглаад юу бүтээгээд яачхав энэ тэр гэсэн зүйл нь хаана байгаа юм. Бид нар чинь цахим үндэстэн болчихсон биз дээ. Цахим яамтай болоод. Үгүй ээ, тэр нь хаана илрээд, хаана гараад байгаа юм. Ямар камер тавьсан юм. Тэр нь стандарттай юм уу. Бүгд ажилладаг уу. Тэгээд нөгөө орон тоо юм хум чинь багасаж байх ёстой шүү дээ үүнтэйгээ нийцээд. Тэр байтугай бид нар энд тэнд явж байхад бол цагдаагийн ганц ч албан хаагчтай гудамжинд таардаггүй. Тэгсэн мөртөө тайван ийм хотууд байгаа шүү дээ. Тэгээд Япон лугаа хөгжье гэж яриад байгаа. Токио энэ тэр чинь тийм шүү дээ.

**Д.Цогтбаатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Энд би нэг хэдэн зүйл цохож хэлье гэж бодож байна. Ганбат гишүүний саяын ярьж байгаа юм зөв. Тийм учраас яг таны ярьж байгаа хуулийн төслүүдийг биш ээ, нэмэлт, өөрчлөлтүүдийг цагдаагийн хуульд оруулах гээд би санаачилчихсан явж байгаа юм. Тэгээд одоо яг тэр камертай холбоотой асуудлууд гэж бодож байна.

Энэ нээрээ Үндсэн хуулийн цэцийн шийдвэр бол ямар сайндаа тогтоолынх нь юу гарч байгаа хүртэл ингээд шууд хүчин төгөлдөр байхгүй юу. Тэгэхээр одоо та бүгдийн хэлж байгаагаар үүнтэй холбогдуулаад бидний одоо бол хэлэлцэж байгаа чинь нөгөө зохих хуульдаа бид нар өөрчлөлт оруулах уу, үгүй юу гэдэг л асуудал үлдэж байгаа юм. Тэгээд яг тэр асуудлаа ч оруулж ирж байгаа юм.

Яах вэ үйлдвэрчний эвлэлийн тухайд гэвэл энэ бол Монгол Улсын Үндсэн хуулиар ард иргэдэд олгогдсон эвлэлдэн нэгдэх суурь эрхийн тухай асуудал

яригдаж байгаа. Харин энэ эрх дээр суурилагдсан байгууллагын эрх мэдэлтнүүд нөгөө эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж байна уу, гуйвуулан ашиглаж байна уу гэх зэрэг асуудлуудыг Энхбаяр гишүүн хөндөж ярьж байх шиг байна. Тэр юу талаас нь бол мэдээжийн хэрэг зохих хууль тогтоомжууд зөрчигдөж байна уу үгүй юу энэ дүгнэлтүүдийг бол хийдэг байх ёстой байх. Түүнээс нөгөө үйлдвэрчний эвлэл маань өөрөө бол эерэг, ард иргэдийн чөлөөт хүсэл эрмэлзлээр бий болсон хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага гэдгээрээ бол энэ ардчилсан нийгмийн маш чухал бүрэлдэхүүн хэсэг. Харин тэрийг буруу ашиглаад байгаа нөхдүүд байгаа бол энэ дээр тэр зохих хууль тогтоомжууд нь ч өнөөдөр байж байгаа. Үүнийхээ дагуу бол хариуцлага бас тооцдог байх ёстой.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтад зохих найруулгын шинжтэй өөрчлөлтийг оруулан хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Би энэ томъёоллыг хэлээд зүйтэй гэж хэдүүлээ хураагаад, би сая хэлчихлээ шүү дээ. Цагдаагийн хуульд угаасаа нэмэлт, өөрчлөлт би санаачлаад явж байгаа юм. Тэр дотроо энэ найруулгынх нь яг найруулгын өөрчлөлт орох болчихож байгаа юм. Тэрийг нь хамт хийгээд явчихъя гээд би протоколд бас тэмдэглээд үлдээчихье гэж бодож байгаа юм. Санал хураалт. Түрүүний уншсан томъёоллоор. 69,2 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд зохих өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

11.28 цаг.

Дараагийн асуудалд оръё.

**Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцье.**

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Жавхлан сайд ирсэн байгаа юу.

Ингээд хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Цогтын Тогосмаа Татварын Ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга гэсэн ийм 3 хүн ажлын хэсэгт оролцож байна.

Ингээд ажлын хэсгийг танилцуулж дууслаа. Товч танилцуулгыг тэгэхээр хэн хийх вэ. Жавхлан сайд нь байхгүй байхлаар чинь. Би тэгвэл өөрөө танилцуулъя. Жавхлан сайд Ерөнхий сайд дээр уулзалтад орчихсон байж байгаа юм байна гарч ирж амжаагүй байна. Манай ажил цаашаа үргэлжлээд явах ёстой. Тийм учраас би шууд танилцуулаад явчихъя.

Үндсэн хуулийн цэцэд иргэн П.Эрхэмбаяр, Л.Лодойсамбуу нар Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн татвар төлөгч нь татварын

хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар Татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэсэн нь мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад санхүүгийн эрх бүхий байгууллага дараах мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ гээд 34.4.1 дэх заалтад Татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр 34.4.3 дахь заалтад Татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг Татварын албанаас бичгээр эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хууль заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжиж баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчиж байна гэсэн мэдээллийг хүргүүлсэн.

Үндсэн хуулийн цэц уг асуудлыг Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа хэлэлцээд Татварын ерөнхий хуулийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн бөгөөд уг маргаанд Улсын Их Хурлаас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Болдын Жавхлан сайд Үндсэн хуулийн цэцэд дараах тайлбарыг хүргүүлсэн.

Нэг.Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн шударга, хүнлэг, ёсыг эрхэмлэн хуулиар ноогдуулсан албан татвар төлөх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэхээр заасан. Улмаар Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3 дахь заалтад татвар бий болгох, тогтоох, ноогдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх зэрэг үйл ажиллагаанд зайлшгүй байх шударга байх зарчмыг баримтлахаар заасан байдаг.

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ноогдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө гэж заасан байдаг боловч Монгол Улсын Үндсэн хуульд заасан шударга ёсыг эрхэмлэн хуулиар ноогдуулсан албан татвар төлөх үндсэн үүргээ ёсчлон биелүүлэхгүй, татвараас зайлсхийх, зугтах үзлүүд гарч байдаг. Иймээс татвар зайлшгүй байх, шударга байх Монгол Улсын Үндсэн хууль Татварын ерөнхий хуульд заасан зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор татварын хууль тогтоомжоор татварын бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж татвар төлөгчийн эрсдэлийг тооцох, энэхүү эрсдэлд үндэслэн хяналт, шалгалт хийх, татвараас зайлсхийх, зугтах явдлаас урьдчилан сэргийлэх, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүргээ татварын алба хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг.

Татварын бүртгэл ноогдуулалтын үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн анхан шатын баримт бүртгэл, гүйлгээ, дансны мэдээлэлд үндэслэн хийгддэг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасан шударга ёсыг эрхэмлэн хуулиар ноогдуулсан татварыг төлөх үндсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах хяналт

тавихад Татварын албаны зүгээс хууль тогтоомжийн хүрээнд холбогдох мэдээ, мэдээлэл, баримт материалыг гаргуулан авах нь зүй ёсны асуудал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй гэж заасан боловч энэ эрхээ хэрэгжүүлэхдээ тус хуульд заасан үндсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй юм. Улмаар татварын байгууллагын зүгээс хуульд заасан үндэслэлээр татвар төлөгчийн дансны мэдээлэл уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээлэл, татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг холбогдох банк, санхүүгийн байгууллагаас авч, хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж заасантай нийцэж байгаа бөгөөд хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлахгүй юм.

Түүнчлэн Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахыг хориглохоор зааж, татвар төлөгчийн мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хуулиар хамгаалсан болохыг онцлох нь зүйтэй байна.

Хоёр.Европын Холбооноос 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсыг татварын зорилгоор ил тод байдал мэдээлэл солилцооны олон улсын форумын гишүүн биш, татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай олон талт конвенцод нэгдэн орж соёрхон батлаагүй гэсэн үндэслэлээр татварын зорилгоор хамтран ажилладаггүй улс орнуудын жагсаалтад оруулсан байдаг. Улмаар Монгол Улс татварын зорилгоор ил тод байдал мэдээлэл солилцооны олон улсын форумд гишүүнээр элсэж, холбогдох стандартыг мөрдөж ажиллах, олон талт конвенцод нэгдэн орох үүрэг амлалт өгснөөр 2018 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр энэхүү жагсаалтаас гарч байсан билээ.

Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны олон улсын форум нь олон улсын хэмжээнд татварын зорилгоор банк мэдээллээ нууцлах, мэдээлэл өгөхгүй байх явдлыг таслан зогсоон татварын ил тод байдлыг хангаж, татвараас зайлсхийх явдалтай хамтран тэмцэх зорилготой дэлхийн 165 улс орныг эгнээндээ нэгтгэсэн институт юм. Энэ байгууллагын гишүүн орнууд татварын зорилгоор банк, санхүүгийн байгууллагад байгаа татвар төлөгчийн мэдээллийг харилцан солилцох дүрэм журмыг даган мөрдөх үүрэг хүлээдэг.

Улмаар Монгол Улс олон улсын форумын гишүүн орны хувьд татварын ил тод байдлыг хангах, татварын зорилгоор банкны мэдээлэл авах, мэдээллийг харилцан солилцохтой холбоотой шаардлага стандартыг Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсэгт тусган хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Европын холбооны өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа хэрэгжүүлж, татварын зорилгоор бусад улстай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, захиргааны туслалцаа харилцан үзүүлэх зорилго бүхий татварын асуудлаар Захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцод Монгол Улс нэгдэн орж Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр уг конвенцыг Соёрхон батлах

тухай хуулийг баталсан. Энэ конвенцын хэрэгжилтийг хангахын тулд Татварын алба, татвар төлөгчийн банк, санхүүгийн байгууллага дахь данс эзэмшигч, дансны гүйлгээний мэдээллийг авах зайлшгүй шаардлагатай байдаг.

Татварын Ерөнхий газар нь банкны мэдээллийн мэдээллийг татварын албаны хөндлөнгийн мэдээллийн санд бүртгэж зөвхөн Татварын ерөнхий газрын даргын эрх олгосон албан тушаалтан нь уг мэдээлэлтэй зохих журмын дагуу танилцаж, хадгалалт, хамгаалалтыг хариуцах эрх, үүрэгтэй байдаг. Харин татварын албаны хэмжээнд бүх албан хаагч мэдээллийг ашиглах болон харах эрхгүй юм.

Татварын ерөнхий хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хувь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэд халдахаас сэргийлэх хүрээнд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Олон улсын 130-9001-2015 Чанарын менежментийн тогтолцоо, 130-1-ЕС27001-2013 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын үүднээс эрхийн тохиргоо мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн журмыг баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд татварын алба нь арилжааны 11 банктэй мэдээлэл харилцан солилцох гэрээг харилцан тохиролцож байгуулсан. Тус гэрээнд заасан арилжааны банкны хүлээх үүрэгт Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтад заасан мэдээллийг сар бүрийн 10-ны өдрийн дотор мөн хуулийн 34.4.1 болон 34.2 дахь заалтад заасан мэдээллийг тухай бүр татварын албанаас албан бичгээр болон тоон гарын үсгээр баталгаажсан цахим хүсэлтийг үндэслэн цахим хэлбэрээр тус тус гаргаж өгөхөөр тодорхойлж тусгасан. Харин татварын алба нь банкнаас ирүүлсэн татвар төлөгчийн дансны мэдээллийг аливаа хэлбэрээр гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй байх, зөвхөн хуулийн хүрээнд татварын зорилгоор ашиглах үүрэг хүлээсэн.

Түүнчлэн татварын алба нь арилжааны банкнаас татвар төлөгчийн дансны мэдээллийг хүлээн авахдаа техник технологийн шаардлага хангасан мэдээллийн системийг бий болгох, цахим сангийн аюулгүй байдал найдвартай ажиллагааг хангасан байх үүрэгтэй. Гэрээний оролцогч талууд нь мэдээллийг чандлан хадгалах үүрэгтэй бөгөөд хууль болон гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахыг хатуу хориглож мэдээллийн нууцлалыг хугацаагүйгээр хадгалах үүрэг хүлээн ажиллаж байна.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд зөрчлөө арилгахгүй байгаа, 1 зөрчлийг 3 ба түүнээс дээш удаа давтан гаргасан эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар тухайн татвар төлөгчийн зөвшөөрөлгүй нийтэд мэдээлж болох тухай заасан нь иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчихгүй. Тус заалт нь 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт татварын хууль тогтоомжийг зөрчсөн нь нотлогдсон, эсхүл татвар төлөхөөс зайлсхийсэн болон эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба энэ хуулийн 14.4-д заасан зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж тусгагдсан байсан зохицуулалт бөгөөд 17 дахь жилдээ үйлчилж байна. Энэхүү хуулийн зохицуулалт нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд зөрчлөө арилгахгүй байгаа, 1 зөрчлийг 3 ба түүнээс дээш удаа

давтан гаргасан эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар тухайн татвар төлөгчийн зөвшөөрөлгүй нийтэд мэдээлж болох тухай заасан нь иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчихгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн шударга, хүнлэг, ёсыг эрхэмлэн хуулиар ноогдуулсан албан татвар төлөх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэхээр заасныг хэрэгжүүлэх ач холбогдолтой.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна гэсэн тайлбар хүргүүлсэн.

Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанаар уг маргааныг хянан хэлэлцээд Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан татвар төлөгчийн талаар Татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн байна гэж шийдвэрлэж, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчөөгүй байна гэсэн дүгнэлтийг тус тус гаргасан байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ийм танилцуулгыг Сангийн яамнаас ирүүлсэн байгааг та бүгдэд уншиж танилцууллаа. Жавхлан сайд ирсэн байгаа юу. Танилцуулгыг хийж дууслаа.

Одоо ингээд итгэмжилсэн төлөөлөгчөөс чинь асуух асуулттай гэхээр одоо итгэмжилсэн төлөөлөгч маань байхгүй байна шүү дээ. Ажлын хэсгээсээ л асуух болж таарч байна тийм үү. Тэгвэл ажлын хэсгээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Татвар санхүүтэй холбоотой Сангийн яамны амбиц гэх юм уу, хууль тогтоомж руу шударга ёсны хэмжүүрээр хэмжихэд их зовлонтой тийм үзэгдлүүд орж ирээд байгаа юм. Тухайлбал яг саяын энэ Үндсэн хуулийн цэц дээр байгаа энэ маргаан, дээр нь санхүүгийн тайлантай холбоотой бас маргаан байгаад байгаа юм.

Тэгээд би нөгөө Сангийн яамнаас асуух гээд байгаа юм. Цаанаа олон улсын байгууллагууд нэгдсэн гэрээ хэлцлийн чинь тайлбарууд яах аргагүй ингээд Монголоос ийм юм нэхээд байдаг юм уу. Хувийн мэдээллийг нь задлах, иргэнийг одоо шийтгэх, торгох, хуулийн этгээдийг татан буулгах гэх мэтчилэн. Тухайлбал санхүүгийн тайлангаа гаргаж өгөөгүй хуулийн этгээдийг улсын хуулийн этгээдийн бүртгэлээс хасах заалт бүртгэлийн тухай хууль дээр Сангийн яамны хүсэлтээр орсон байгаа байхгүй юу. Хуулийн этгээдийг дампууруулж болно. Хуулийн этгээдийн бүртгэлээс захиргааны аргаар хасах ямар ч боломж байх ёсгүй шүү дээ. Үндсэн хуулийн цэц сая ингээд энэ татварын хууль тогтоомжтой холбоотой Үндсэн

хуулийн цэцийн дүгнэлтийг хараад Үндсэн хуулийн цэцэд нэг дэвшил гарч байна гэж бодож байна. 2 жилийн өмнө нь Үндсэн хуулийн цэц санхүүгийн тайлан татварын тайлан 2-оо ялгагдаггүй байсан шүү дээ. Одоо Цэцийн тэр шийдвэрүүд дээр байж байгаа. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал ийм байна гээд өгөхөд Үндсэн хууль дээр татвар төлөх нь иргэний үндсэн үүрэг учраас гээд тэр татварын тайлантай холбоотой асуудлаар ерөөсөө цэц дээр маргаан үүсгээгүй байгаа байхгүй юу. Тэгэхэд тийм хариу Үндсэн хуулийн цэц өгч байсан шүү дээ.

Тэгээд одоо Сангийн яам бол эрх биш санхүүгийн тайлан, татварын тайлан хоёроо ялгадаг байх гэж бодож байна. Үнэхээр цаана байгаа Европын холбоо гээд энэ дээр Европын холбооны татвартай холбоотой харилцан туслах гэдэг юм уу, хамтран ажиллах тухай ярьж байгаа байхгүй юу. Тэр Европын холбоонд байгаа улс орнууд чинь шүүхийн зөвшөөрөлгүйгээр санхүүгийн, татварын байгууллагын хүсэлтээр банкны мэдээллүүдийг нь Сангийн яам буюу эсвэл нэг ийм төрийн захиргааны байгууллага шууд гаргаад өгчихдөг зохицуулалттай юм уу. Харьцуулсан судалгаа байгаа юм уу 1.

2-т нь та хэд яг энэ дээрээ гуравдагч этгээдэд гаргаж өгөхгүй гэж хэлж байгаа боловч танай байгууллагын хүмүүс чинь шүүх дээр гэрчээр дуудагдаад Хөгжлийн банк энэ тэр дээр гуравдагч этгээдүүдэд бүр мэдээллээ өгөх битгий хэл хуулийн байгууллагуудын хамтран ажиллагч болоод сууж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ гуравдагч этгээдэд мэдээлэл гаргаж өгөхгүй гэдэг дотор нь хуулийн байгууллагууд орж байгаа юм уу, ороогүй юм уу. Тэрийг нь бас ингээд бүр тодорхой сонсмоор санагдаад байгаа байхгүй юу.

**Д.Цогтбаатар:** Ажлын хэсгээс хэддүгээр микрофон хариулах вэ. 6 дугаар микрофоныг өгье. Маш чухал асуулт асууж байна шүү. Тэгээд Тэмүүжин гишүүн эртээд бол Хууль зүйн байнгын хороог төлөөлж Улсын Их Хурал дээр чухал мэдэгдэл хийсэн шүү. Юу гэвэл сайд нар барин тавин шууд худлаа яриад байна. Тэгээд худлаа ярьж байгааг мэдэхгүй хүмүүс энд сууж байгаа гэж найдаад, энэ чинь мэддэг хүмүүс зөндөө сууж байгаа шүү. Тийм учраас хариултаа яг тодорхой өгнө шүү. Тэр гадаадын байгууллагууд чинь тийм мэдээллүүдийг жишээлбэл банкны гүйлгээ мэдээллүүдийг нь шууд гаргаад өг гээд шаардаад байдаг юм уу. Аливаа нэгэн хуулийн заалт шаардлагагүйгээр зөвхөн та нарт тийм үзэмжийн эрхийг олгочоод байгаа юм уу. Тэр юмнууд дээрээ хариулна уу.

**Б.Тэлмүүн:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Тэмүүжин гишүүний асуултад хариулъя. Татварын ил тод байдалтай холбоотой асуудал бол 2017 оноос хойш дэлхий нийт дээр яригдаад, тэгээд жи7, жи20-оос гаралтайгаар Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага дээр энэ асуудал төвлөрөөд, тэгээд Глобал форум гэдэг ийм бүтэц бол байгуулагдсан. Энэ байгууллагаас гаргаж байгаа дүрэм журмууд бол 1 дүгээрт татварын ил тод байдлыг хангах, 2 дахь нь бол татварын зорилгоор харилцан мэдээлэл солилцох гэсэн үндсэн агуулгатай. Монгол Улс 2017 онд Европын холбооны татварын зорилгоор хамтарч ажилладаггүй улсуудын жагсаалтад орсон нэг үндэслэл нь бол эдгээр дүрэм, журам, стандарт, ил тод байдлыг хангахгүй байна, ийм үүрэг хүлээхгүй байна гэсэн үндэслэлээр бол тухайн жагсаалтад орсон байдаг.

Тэгээд жагсаалтаас гарахын тулд бид Европын холбоонд үүрэг амлалт өгөөд Глобал форумд элссэн. Энэ байгууллагаас тавьдаг үндсэн шаардлага бол татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох стандартыг хэрэгжүүл. Үүнтэй

холбогдон гарсан конвенцуудад элсэж ор гэдэг ийм үндсэн асуудал байгаа. Олон улсын түвшинд бол яг татварын зорилгоор банкны нууцлал гэдэг асуудал ер нь байхгүй болсон байгаа. Банк секреси буюу оффшор бүсүүд Швейцар ч гэдэг юм уу бүх улсууд бол татварын зорилгоор харилцан мэдээлэл солилцох ийм боломжтой болсон. Энэ дээр бол тэгэхдээ зөвхөн татварын зорилгоор гэдэг ийм тодотголтой байгаа. Үүнтэй холбоотойгоор Монгол Улс бол татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай ЭЗХАХБ-ын конвенцод 2020 оны 1 сарын 3-ны өдөр соёрхон батлах тухай хуулиа баталж, энэ конвенцод элсэж орсон. Үүний дагуу гадаад улсаас эрх бүхий байгууллагаас гадаад улсын татвар төлөгчийн мэдээллийг хүссэн тохиолдолд манайх хүсэлтээр болон автоматаар мэдээллийг нь гаргаж өгөх ийм үүрэг хүлээсэн байгаа.

2 дугаарт бол татварын ЭЗХАХБ-ын энэ бепстэй холбоотой дүрэм журмууд бол ер нь банк татварын алба өөрөө банкны мэдээлэлд нэвтэрч байж энэ татвараас зайлсхийхийн эсрэг энэ дүрэм журмуудыг хэрэгжүүлэх боломж бүрддэг гээд энэ асуудлыг тавьдаг. Үүнтэй холбоотойгоор 2019 оны 3 сарын 22-ны өдөр батлагдсан Татварын ерөнхий хууль дээр мэдээлэл авахтай холбоотой ил тод байдлыг хангахтай холбоотой зохицуулалтууд орсон байдаг. Үүнтэй зэрэгцээд бид бол яг тухайн үед татвар төлөгчийн нууцлалтай холбоотой бүхэл бүтэн зүйлийг оруулаад энэ дээр татварын алба, татвар төлөгчийн мэдээллийг хуульд зааснаас өөрөөр ашигласан тохиолдолд хариуцлага хүлээхтэй холбоотой зохицуулалтуудыг бүр нэгтгэж зохицуулсан ийм харилцаанууд байдаг.

Таны асуусан 2 дахь асуулттай холбоотой хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 26.1 дэх зүйлтэй холбоотой асуудлыг асуусан гэж ойлголоо. Энэ дээр бол санхүүгийн тайлангаа 8 болон түүнээс дээш улиралд дараалан гаргаагүй харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах талаар саналаа Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэж, улсын бүртгэлийн байгууллага нийтэд зарлаад, зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр эсвэл цахим хэлбэрээр санал, гомдол гаргаагүй, дампуурлын хэрэг үүсээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр төлбөргүй бол тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна гэсэн ийм зохицуулалт байдаг. Тэгэхээр энэ дээр бол яах вэ, яг хууль дээр бол хэд хэдэн нөхцөлүүдийг бол заасан. Сангийн яамны хувьд бол саналаа хүргүүлдэг. Үүнтэй холбоотой ямар нэг өр төлбөр байхгүй, бүр огт тайлангаа гаргаж байгаагүй ийм компаниудын судалгааг бол татварын албанаас аваад санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тулгаад бол хүргүүлдэг. Энэ зохицуулалтын дагуу явж байгаа. Энэ дээр бол татварын болон санхүүгийн байгууллагын хувьд үр ашигтай байх гэдэг энэ зарчимтай холбоотой .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Харин энэ зохицуулалтыг би ерөөсөө ойлгохгүй байгаа. Үүнтэй холбоотой асуудал дээр би Сангийн яамнаас тухайлан юу авах гээд байгаа юм. Энэ санхүүгийн тайлан гэдэг ойлголт нь Монгол Улсын хувьд иргэнийг үүрэгжүүлж, хариуцлагажуулах ёстой тийм мэдээлэл үү. Энэ мэдээллийг яагаад та бүхэн ингэж ойлгоод байгаа юм. Миний ойлгосноор санхүүгийн тайлан гэдэг энэ зүйл нь компанийн нууц байгаа байхгүй юу. Зөвхөн компанийн өмчийн эздийг өмчөө захиран шийдвэрлэхэд нь туслах зорилготой санхүүгийн мэдээллээр хангахад зориулсан төрийн зөвлөн туслах чиг үүргийн нэг хэсэг байхад санхүүгийн тайланг



нь яагаад Сангийн яам албадаж авдаг систем тогтоочхов. Зөвхөн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангахын тулд шүүхээр компаниас авдаг мэдээлэл байгаа байхгүй юу. Төр авах бол төрөөс чиг үүрэг шилжүүлж авсан юм уу, тендерт .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Гүйцээгээд микрофон өгье.

**Х.Тэмүүжин:** Төр авах бол төрөөс чиг үүрэг шилжүүлж авсан юм уу, эсвэл тендерт оролцож байгаа компаниас энэ үйл ажиллагааг хэрэгжүүлж чадах уу үгүй юу гэдэг санхүүгийн төсөөлөл авахын тулд авдаг мэдээлэл болохоос биш тэрнээс бусад хуулийн этгээдээс ингэж албадаж авдаг, өгөөгүй бол торгодог Зөрчлийн хууль дээр бүүр хэд хэдэн зүйлээр торгууль бичсэн байна лээ. Тэгээд сүүлд нь бүр хуулийн этгээдээс хуулийн этгээдийн жагсаалтаас хасаж байгаа байхгүй юу бүртгэлээс. Хуулийн этгээдийн бүртгэлээс хасдаг энэ зохицуулалт нь өөрөө яг үндсэндээ бол хувь хүн нөгөө өмчтэй байх, хувийн хэвшил эрхлэх энэ тэр гээд маш олон Үндсэн хуулийн заалтууд дээр бүр очоод зөрччихөж байгаа юм. Хуучин бүртгэлийн энэ хуулийн заалт нь юу байсан гэхээр үйл ажиллагаа явуулдаггүй компаниуд байгуулсан хүмүүс нь өөрсдөө хүсэлт гаргахаар хуулийн этгээдийн бүртгэлээс хасдаг зохицуулалттай байсан. Тэгсэн чинь одоо энэ нь Сангийн яамнаас санал очоод, тэгээд .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Ажлын хэсгээс хэддүгээр микрофон өгөх вэ. 4 дүгээр микрофон.

**Ч.Чимидсүрэн:** Санхүүгийн тайлан гаргах, түрүүний нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах үйл ажиллагаа бол Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар зохицуулагдсан байдаг. Санхүүгийн тайлан бол өөрөө олон нийтэд зориулагдсан ийм тайлан. Тэгэхээр зөвхөн эздэд биш, олон нийтэд степ холдерууд хэлдэг бүхий л оролцогч талуудад нээлттэй байдаг ийм мэдээллийг бид нар санхүүгийн тайлан гэж байгаа. Татварын тайлан нь бол тусдаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсын татварын хууль дүрэм журмаар бэлтгэгдсэн энэ тайлангийн асуудал явагдаж байгаа.

Яах вэ улсын бүртгэл дээр бид нар нөгөө хуульд оруулсан нэг шалтгаан нь болохоор нөгөө аж ахуйн нэгж, байгууллага байгуулахад бол их хялбар байгуулагдаад явчихдаг. Тэгээд бидний тоо статистикууд ингээд мэдээлэхдээ зэрэг ингээд хий тоо аж ахуйн нэгжүүдийн тоо ихээр нэмэгдээд гараад явчихдаг. Тэгээд тайлан мэдээгээ гаргадаггүй .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Гүйцээж хариулах уу. 4 дүгээр микрофон өгье.

**Ч.Чимидсүрэн:** Тэгээд хий тоо өсдөг. Тэгээд нөгөө тайлангийн ирцэд маш багаар илтгэгдээд явдаг. Иймэрхүү шалтгааны улмаас ингээд үйл ажиллагаа 8 улирал дараалан явуулаагүй санхүүгийн тайлан мөн татварын байгууллагад байгаа мэдээллүүдээрээ бас олон жил үйл ажиллагаа нь явагдаагүй нотлогдсон байгууллагуудыг бас цэвэрлэх зорилгоор Улсын бүртгэлтэй гуравласан хэлбэрээр мэдээллийг нь солилцоод, энэ хуулийн заалтын дагуу хасалтыг нь хийгээд явж байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Тэмүүжин гишүүн их зарчмын асуудал хөндөөд байгаа юм. Ер нь татварынхны лоббигоор зөрчлийн хэрэг хянан шийтгэх ажиллагаанаас өөр хуулийн хорио хандалтаас гадуур байх, том дүнтэй татварын маргаануудыг өөрсдөө шийдэх гэдэг энэ лобби бол олонтоо явагдаж ирснийг би бас түрүүчийн парламентын үед бас ярьж байсан. Энэ санхүүгийн тайлангаа өгөөгүй компаниудыг улсын бүртгэлийн хуулийн этгээдийн бүртгэлийн жагсаалтаас хасах гэдэг ийм хуулийн заалт захиргааны аргаар хуулийн этгээдүүдийг хэрэг дээрээ би ашиглан татвар хэлж байгаад татан буулгачих ийм хуулийн хөшүүрэг оруулсан байсан. Энийг бол миний хувьд сая хавар улсын бүртгэлийн асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүнээр ажиллаж байх үед хэдэн мянган хуулийн этгээдүүдийг ийм байдлаар цахим бүртгэлээс хасаад, энийгээ нууж байсныг бол илрүүлсэн. Тэгээд энэ бол их ноцтой асуудал байгаа юм. Яагаад гэхээр тухайн хуулийн этгээдүүд өөрсдөө банканд өртэй, авлагатай эсвэл иргэн хуулийн этгээдүүдээс өртэй, авлагатай, эд хөрөнгийн маргаантай, бизнесийн хэлцлүүдтэй явж байхад энэ асуудал шүүхээр ороогүй байж байхад тэнд зүгээр татварт тайлангаа өгөөгүй гээд тэр компанийг хэрэг дээрээ татан буулгачихсан байна гэсэн. Эзэн нь ч өөрөө мэдээгүй. Энэ бол нэлээн татварынхан ийм байдалтай хуульд оруулж ийм захиргааны аргаар явдаг асуудал бол байж болохгүй. Энэ дээр их ноцтой анхаарал, дүгнэлт хийх ёстой.

Яг тэрэнтэй адилхан би энэ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт бол 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Цэцийн 4 тоот дүгнэлт бол Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд жишиг болох маш том дүгнэлт гаргасан байна гэж үзэж байна. Энэ дүгнэлтийн зөвхөн үндэслэл хэсэг бол 13 хуудас байна. Энэ дотроо хэд хэдэн асуудлыг хөндсөн байна.

1 дүгээрт хүний халдашгүй байх эрхийг Үндсэн хуулийн цэц маш өргөн хүрээнд авч үзэж, тайлбарласан байна. Энийг ер нь цаашдаа яаж ойлгох вэ гэдэг дээр.

2 дугаарт Үндсэн эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гэдгийг бараг анх удаа, 35 жилийн хугацаанд анх удаа дэлгэрэнгүй тайлбарласан байна..../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Микрофон гүйцээгээд өгье.

**Б.Энхбаяр:** Тийм учраас энэ тайлбар бол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, тэр дотроо хууль боловсруулдаг Хууль зүй, дотоод хэргийн яам, бүх шатны хуулиудыг хэрэглэж шийдвэр гаргадаг шүүхүүд, бүх шатны шүүх, хүний халдашгүй эрхэд халдах эрх бүхий бүх шатны хуулийн байгууллага, гүйцэтгэх эрх мэдлийн бүх байгууллагуудад хамаатай ийм Цэцийн дүгнэлт гарсан байна. Өөрөөр хэлбэл хуульд заасан үндэслэл журмаар дур зоргоор дур мэдэж хүний халдашгүй эрхэд халдах гэдгийг цаашид хууль тогтоогч ямар хүрээ хязгаарт ойлгож явах ёстой вэ гэдгийг энд шууд хэлж өгсөн байна.

Тийм учраас энийг бүх шатын шүүхүүдэд, Хууль зүйн яам, Улсын Их Хурлын Тамгын газарт энэ цэцийн дүгнэлтээр цаашид сургалт орох хэрэгтэй байна.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Үг хэлчихлээ гэж би ойлголоо. Асуулт, үг хамт гээд би нээрээ хэлчихсэн байгаа. Түрүүнийх дээр хамт байсан. Энэ тусдаа тусдаа байгаа. Ганбат гишүүний микрофоныг өгье.

**Д.Ганбат:** Яах вэ, бид нар бас сайн ярьж хэлж баймаар юм шиг байгаа юм. Бас олон нийт ард түмэн бол сонсоод сууж байдаг. Бас өөрийнхөө эрхийг мэдэж авдаг. Манай Байнгын хороо, манай Их Хуралд бол маш их чадварлаг гишүүд байгаа юм л даа. Энэ Засгийн газрыг гайхаад байгаа юм. Асуух гэхээр Жавхлан сайд алга уу. Тэр их сонин байна. Ер нь бол олон нийт тэгээд байна л даа. Засгийн газар чинь баахан суганы үснүүдээр дүүрчихсэн байна гээд. Тэд нарын л яриа шүү дээ. Тиймэрхүү байдалтай. За яах вэ бас нэг зарчим байна л даа. Энэ төр засагт бол зөвшөөрөөгүй юм болгоныг хориглосон, зөвшөөрөөгүй бүх бүх юмыг эд нар хийх эрхгүй. Ард түмэн, аж ахуйн нэгжид бол хориглоогүй бүх юмыг хийх эрхтэй. Ер нь манай Үндсэн хууль, манай хуулиудын зарчим ерөөсөө энэ шүү дээ. Тэгээд татварын алба чинь хэчнээн хүнтэй байна. Хэчнээн байцаагчтай байдаг юм. Тэр бүх байцаагч нар дурын хүнийхээ бүгдээрээ татвар төлөгчид шүү дээ. Энд нэвтрэх эрхтэй байна уу. Энэ мэдээллийг дурын татварын байцаагч үзээд харах эрхтэй байгаа юу. Ямар байгаа юм.

Харин Үндсэн хуулийн цэцийн энэ шийдвэртэй бол ёстой санал нийлж байна. Яг энэ хууль, энэ Үндсэн хуулийн агуулга юманд бид нар иргэдээ бол бас халдашгүй байх, өмч хөрөнгө нь халдашгүй байх энэ бүх тал руугаа орох хэрэгтэй л дээ. Тэгээд бас олон юм яримаар байна уг нь бол. Гадна, дотно баахан жүжиг тавиад л, баахан мөнгө төгрөг олоод л үгүй ээ ингээд тэр Токиогийн метронд ч юм уу, Сингапурын метронд энэ тэр бүжиглэж бариад л их мөнгө олоод байх нь хаашаа юм. Тэр нь бүртгэлтэй байдаг уу. Хууль ёсны мөнгө болдог уу. Ямар байдаг юм бол. Бас манай татвар дээр бүртгэгддэг үү гэсэн ийм асуулт байх юм.

Нөгөө талаар бол нэмүү өртөг гэж байна. Нэмүү өртгийн татвар гээд 2 хувийг нь буцааж өгдөг л дөө. Баахан санал асуулга яваад 100 мянга гаруй хүн 5 хувийг нь буцааж өгдөг болъё гээд иймэрхүү юм байсан. Тэгээд тэр чигээрээ байхгүй болчихлоо л доо. Бүгдээрээ л татвар төлөх ёстой. Тэр зах дээр бол НӨАТ-ын баримт өгөөд бариад байгаа юм алга байна. Энэ юм чинь яагаад хийгддэггүй юм бэ. Тэр бэлэн мөнгөөр маш их мөнгө энэ гаднын наймаачдын гарт бие биедээ шилжүүлж, ингэж наймаа явагдаж байна гэсэн ийм мэдээллүүд байдаг. Өөрийнхөө орныхоо иргэдийг л бид нар одоо янз бүр болоод ингээд шахаад дарамтлаад байхаас биш, гадна дотноос энэ дотор чөлөөтэй .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Тодруулах уу. Хэддүгээр микрофон хариулах вэ. 4 дүгээр микрофон.

**Ч.Чимидсүрэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Татварын Ерөнхий газар Чимэдсүрэн. Тэгэхээр дурын иргэний дансны мэдээллийг хараад байдаг уу гэсэн 1 дүгээр асуултад нь хариулъя.

Тэгэхээр одоо бол улсын бүртгэлд бүртгэлтэй 2.000.454 иргэн бол байна. 256 мянган аж ахуйн нэгж, идэвхтэй үйл ажиллагаатай 160 мянган аж ахуйн нэгж байгаа юм. Тэгэхээр 2020 оны татварын шинэчлэлээр бол эрсдэлд суурилж татварын хяналт шалгалтыг хийдэг болсон байгаа. Тэгэхээр татварын өөрт байгаа их дата өгөгдөл дээрээ үндэслээд, бид нар эрсдэлтэй гэсэн татвар төлөгчөө бол

хяналт шалгалтад хамруулдаг байгаа. Энэ тогтолцоо нэвтрээд үндсэндээ 4 дэх жилдээ явж байна. Энэ хугацаанд бол татвар төлөгчдийн тоо жилээс жилд үгүй ээ хяналт шалгалт хийж байгаа аж ахуйн нэгж, иргэний тоо бол буурч байгаа. Одоо хуучин энэ хуульд нэвтрэхээс өмнө бол жилд 5-6 мянган аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийсэн үе байсан бол одоо энэ эрсдэлд суурилснаар бол 1500-2000 орчим аж ахуйн нэгж, байгууллага дээр бол хяналт шалгалтын үйл ажиллагаа хийж байна. Тэгэхээр энэ хяналт шалгалттай холбоотой үйл ажиллагааны явцад эрсдэлтэй гэж үзсэн тухайн байгууллагын дансны мэдээлэлд тэр эрх бүхий хяналт шалгалт хийж байгаа байцаагч нарын хүрээнд л орж байгаа. Тэрнээс биш бүх иргэдийнх рүү бүх байцаагч нар бол ороод явдаг зүйл байхгүй байгаа.

**Ц.Тогосмаа:** Татварын ерөнхий газрын Хууль хэрэгжилтийг хангах газар Тогосмаа. Ганбат гишүүний 2 дахь асуултад нь хариулья.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр бол татварын алба хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд бол сургалт сурталчилгааг явуулж байгаа. И-баримт буюу НӨАТ-ын төлбөрийн баримттай холбоотойгоор зах худалдааны төвүүд дээр хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх чиглэлээр бол сургалт сурталчилгааг явуулж байна. Зөрчил, дутагдал гарсан тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцоод төлбөрийн баримтыг олгуулах захиргааны процесс ажиллагааг бол хэрэгжүүлээд явж байгаа.

**Д.Цогтбаатар:** Гишүүд асуулт асууж дууслаа. Надад зүгээр нэг асуулт байна. Түрүүн Энхбаяр гишүүний асуусантай холбогдуулаад асуучихмаар байна. Энэ чинь эзэн нь мэдээгүй байхад захиргааны журмаар та нар компани татан буулгаад байгаа тийм юм байгаа юм уу. Энэ чинь яагаад гэвэл бас ноцтой юм ярьж эхэлж байна шүү дээ. Тийм бодитой юм байгаа юу. Та нар тэр дээр хариулаач.

Хэддүгээр микрофон бэ. Сангийн яам. 6 дугаар микрофон.

**Б.Тэлмүүн:** Энэ харилцаа бол Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 26.1 дээр санхүүгийн тайлантай холбоотой байгаа. Татварын алба ямар нэгэн байдлаар хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах тийм эрх мэдэл бол хуулиар бол байхгүй. Энэ дээр бол санхүүгийн тайлангаа 8 болон түүнээс дээш улирал гаргаагүй 1, санхүүгийн тайлангаа ерөөсөө илгээгээгүй тохиолдолд Сангийн яам саналаа гаргаад улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлдэг. Улсын бүртгэлийн байгууллага өөрийн цахим хуудсаараа нийтэд зарлаад 6 сарын дотор гомдол, санал аливаа хэлбэрээр ирээгүй тохиолдолд, мөн дампуурлын хэрэг үүсээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрийн тогтоогдсон өр төлбөргүй бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага өөрөө хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах үйл ажиллагаа явуулдаг ийм хуулийн зохицуулалттай. Татвартай холбоотой татварын байгууллагаас бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийг ингэж өөрчлөх, хасах ийм харилцаа бол байхгүй.

**Д.Цогтбаатар:** Тэгэхээр миний яг асууж байгаа. Наадах чинь ингээд эрх зүйн асуудал гараад ирж байгаа байхгүй юу. Улсын бүртгэлийн газар олон нийтэд зарлаж байна шүү дээ. Тэр олон нийтэд зарлаж байгаагаар тэр эзэнд нь зарлаж байна гэж та нар үзэж байгаа юм уу. Яагаад гэвэл олон нийтэд зарлахаасаа илүү тэр эзэн өөрөө мэдэх ёстой байхгүй юу. Тэгэхээр та нарын ярьж байгаад чинь олон нийтэд зарлаж байгааг эзэнд нь шууд автоматаар зарлалаа гэж үзэх хэцүү

шүү дээ. Тэгэхээр яг эзэнд нь та нар түрүүлж зарладаг уу л гэж асуугаад байхгүй юу. 6 дугаар микрофон.

**Б.Тэлмүүн:** Өнөөдөр бол Цэцийн дүгнэлттэй холбоотой бид нар материал бэлтгэж ирсэн. Яг энэ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага яаж зарладаг вэ, зарлахдаа ямар процессоор явдаг вэ, гомдлоо яаж авдаг вэ гэдгийг бид бол шууд хариулах боломжгүй байна.

**Д.Цогтбаатар:** Тэгвэл та нар энэ дээр надад жич тайлбар дараа нь орж ирээд ч юм уу өгчхөөрэй. Ер нь энэ бол ноцтой асуудал гарч ирж байна шүү нээрээ.

Ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Орохгүй байгаа гишүүн байна уу. Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүн үг хэлэхдээ асуултаа асуух боломжийг нь олгочихъё. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Яг энэ цэцийн дүгнэлт бол ....

**Д.Цогтбаатар:** Түр байж байгаарай. Заяабал гишүүн үг хэлэх юм байна. Оруулъя. Эрдэнэболд гишүүн үг хэлэх юм байна. Оруулъя. Ингээд Эрдэнэболд гишүүнээр тасаллаа.

**Х.Тэмүүжин:** Цэцийн дүгнэлт бол үндсэндээ 2 чухал зарчмыг тодотгох гэж оролдсон байгаа.

1 дүгээрт бол иргэний эрх чөлөө, иргэний бизнес, хувийн хэвшлийн ажил эрхлэлт гэдэг энэ зүйл өөрөө Монгол Улсад Үндсэн хууль байгаагийн утга учрын нэг гол зарчим шүү. Энийг хангахын тулд төр засаг байгаа гэдгийг тодотгох гэж оролдож байгаа суурь шинжтэй нэг зарчим явж байна.

2-т нь энэ хуулийн засаглал тогтоох энэ зорилго нь төр хуулиар иргэдийг засаглахаасаа илүүтэйгээр хувийн эрх чөлөөг хуулиар хамгаалах гэж байгаа шүү гэдэг энэ зарчмыг бас тодотгох гэж оролдож байгаа юм.

Тэгээд сая ингээд ярианууд дунд гарч байгаа нэг хандлага байгаа юм. Манай Засгийн газар төр өөрийнхөө ажлыг хөнгөвчлөх зорилготойгоор хууль руу өөрийнхөө хийх ажлыг ял шийтгэл болгож, иргэдэд үүрэг болгож ингээд үүрүүлдэг ийм хандлагатай болоод хувирчихсан. Иргэдэд яаж дарамт учруулах вэ, яаж хүндрэл бий болгох вэ, яаж энийг айдас хүйдэс болгох вэ гэдэг тэр арга барил нь. Өнөөдөр ингээд үгэн дотор гарч байгаа биз дээ. Төр нь өөрөө ингээд иргэдийнхээ бизнес эрхлэлт, ажил эрхлэлтийг гээд цэвэрлэгч болоод хувирчихсан. Таалагдахгүй аж ахуйн нэгж, өөрсдийнхөө үгээр байхгүй аж ахуйн нэгжийг цэвэрлэдэг маягийн тийм хандлага гарч ирж байгаа байхгүй юу. Тэгээд түрүүний одоо энэ татварын хууль тогтоомж дээр ч болов, тэр санхүүгийн бүртгэлтэй холбоотой хэсэг дээр ч болов дахиад ингээд харагдаж байгаа нэг зүйл нь юу вэ гэхээр ингээд яамдууд өөрийнхөө амбицыг хууль руу оруулж ирээд, иргэдэд үүрэг хариуцлага шийтгэл шиг бичдэг болчихсон байгаа зүйлийг зогсоох механизм ер нь бол энэ төрд байна уу, үгүй юу гэдэг дээр бид нар ярилцах цаг болчихсон. Яагаад зөрчлийн хуулийг иргэд маш их хүчтэйгээр ад үзэж байна вэ гэхээр Зөрчлийн хуулиар дамжуулж, төрийн байгууллагууд ажлаа хөнгөвчилдөг болчихжээ. Сая

бүртгэлийн хууль дээр гарч байгаа тэр зүйл ч гэсэн тэр. Иргэд, эзэн нь мэдээгүй байхад хуулийн этгээдийг нь үгүй хийчхэж байгаа байхгүй юу. Төрийн бус байгууллага байна. Компани байна, ямар нэгэн холбоо, сангууд байна. Төр өөрөө ил тод байдлаа бүрэн дүүрэн хангаж чадахгүй байгаа мөртөө иргэнээс хамаагүй илүү ил тод гэдэг юм уу ингээд өөрийнх нь бизнестэй холбоотой нууцыг хүртэл ил байх ёстой гэдэг шаардлагыг тавих хэмжээний хүчирхэг болоод хувирчихсан байгаагийн тод илрэл үүгээр харагдаж байгаа юм. Тэгээд болоогүй хувийн мэдээллийг нь бидэнд таалагдахгүй бол хэдий хэмжээнд бид нар задалж чадна гэдгээ бас энэ хууль тогтоомжийн цаана концепц байдлаар биччихээд байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг л таслан зохих хэрэгтэй шүү гэдэг сануулгыг Үндсэн хуулийн цэц шийдвэртээ нэгд тусгасан байна.

2-т нь Улсын Их Хурал. Одоо энэ Татварын тухай хууль тогтоомж бол Хууль зүйн байнгын хороогоор ороогүй л явсан. Түрүүн Зөрчлийн хууль дээр бичигдсэн маш олон заалтууд иргэд рүү үүрэг, хариуцлага болж очсон маш олон заалтууд Хууль зүйн яам, Хууль зүйн байнгын хорооны хяналтаас гадуур явж байсан. Тэрний үр дагаврууд одоо ингээд дахин дахин хууль дээр гарч ирээд байгаа юм. Хэзээ ямар байгууллага, ямар хуульд хавчуулаад ийм зүйлийг оруулаад ирсэн нь мэдэгдэхгүй. Иргэн дээр дарамт болж байгаа ийм зохицуулалт бол зөндөө байгаа. Тэгээд би бол энэ дүгнэлтийг хүлээж авахаасаа гадна Хууль зүйн байнгын хороо ер нь Засгийн газарт чиглэл өгдөг юм уу, эсвэл өөрсдөө ажлын хэсэг байгуулдаг юм уу, энэ шударга гэдэг хуулийн хэмжүүрээр хэмжигдэхгүй байгаа иргэнд үүрэг хариуцлага .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Гүйцээгээд микрофон өгье.

**Х.Тэмүүжин:** Шударга, хууль ёсны гэдэгт хэмжигдэхгүй байгаа иргэнд үүрэг хариуцлага оногдуулаад байгаа хууль тогтоомжууд дээр бид нар мониторинг хийх цаг болсон байх. Тэгэхгүй бол иргэд бол тэгээд байна лээ. Энэ хуулийг чинь бидэнд үүрэг болгож байгаа, хариуцлага болгож байгаа маш олон зохицуулалтууд ухаалаг биш байна. Нийгмийн хөгжлөөсөө хоцрогдсон байна. Хүний эрхэд халгаатай байна. Хөгжил дэвшил рүү урагшаа явах гэхээр дандаа хориг саад болсон хэлбэр дүрстэй байгаад байна. Үүний чинь ард ямар нэгэн яамны ямар нэгэн эрх мэдэлтний ямар нэгэн даргын эрх мэдэлтэй байх гэсэн амбицууд харагдаад байна. Тэгээд энэ дээрээ нэг тийм дүн шинжилгээ хийгээд, аль нь зөв зохистой шударга ёсны гэдэг хэмжүүрт ойртож очих, очихгүйгээр нэг зааглаач. Тэгэхгүй бол энэ хүн суртал тодорхойгүй байдал, дээр нь хуулийн ийм үүрэг хариуцлага хэт бий болгосон энэ дарангуйлал чинь бизнес эрхлэлт бол .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Чухал санаа хэлж байна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Би ямар ч байсан 2 зүйл хэлнэ. Тэгээд бас манай гишүүд маань тодорхой өөр өөрсдийн дүгнэлтээ хийгээд, итгэл үнэмшлээр шийдэж байгааг би ойлгож байгаа. Тэгэхдээ 1 зүйлийг бас анхаарах ёстой юм. Бид хэд өмчийн асуудал гэдэг бол энэ өмчийн харилцаа, энэ өмчтэй дагалдаж орж ирж байгаа өмчлөгчөөс гадна үүний үр шимийг хүртэх гэдэг юм уу, янз бүрийн байдлаар гэрээний харилцаанд орж байгаа, нөгөө талд нь харилцагч байгаа гэдгийг бас ойлгож авч үзэх ёстой. Тэгэхээр энэ зүйл байгаа шүү гэдэг зүйлийг хэлье.

Энхбаяр гишүүний түрүүний ярьж байгаа бол ноцтой. Уг нь бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль яг энэ агуулгыг хийгээгүй юм. 26.1.эзэнд нь мэдэгдэнэ. Энэ амьгүй зомби компаниудыг цэгцэлж явахгүй бол маш их хэмжээний тоо байгаад байдаг, үйл ажиллагаа явдаггүй гэдгээр манай эдийн засгийн суурь индикатор хүртэл буруу гардаг.

2 дугаарт улсын бүртгэл дээр амьд байгаад байхаар цаана нь залилангийн хэргүүд явдаг байхгүй юу. Эдгээр компаниудаар ашиглагдаж. Тэгэхээр энэ нөгөө өмч хөрөнгүүд дампуурлын хэрэг үүсэж болдоггүй ийм зүйлүүдийг уг нь цэгцлэх гэж байсан юм. Тэгэхээр өмнө нь техникийн шийдлээрээ яг иргэнд нь мэдэгддэг ядаж И-монголиагаар мэдэгддэг, хуудас цаасаа хүргүүлчихдэг тэгээд энэ компанитай холбоотой өр төлбөр, авлагатай хүмүүс байна уу гээд мэдээлж байгаа процедур энэ байхгүй юу. Энэ дээр алдаа гаргаад яг эзэнд нь мэдэгдэхгүйгээр хуулийн этгээд татан буугдаж байгаа бол энийг анхаарах асуудал. Би энийг бол хүлээн зөвшөөрч байна.

Цэцийн дүгнэлт рүүгээ эргээд оръё. Яг энэ өмчийн асуудал дээр. Би бол энэ цэцийн 13.4 дээр бол Үндсэн хууль зөрчсөн байна. 34.4.1 дээр бол Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж гаргасан юм байна. Яах вэ, зүгээр 13.4-ийн агуулга бол би уг нь бол энэ зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэхээсээ илүүтэйгээр мэдэгдээд нийтэд мэдээлэх ёстой байхгүй юу. Яг энэ асуудал дээр. Бусад дүрэмд бол энэ татвар төлөөгүй энэ асуудал татварын тайлан энэ тэр бол ил тод байж байж энэ дээр нь татварын байцаагчид гэхээсээ илүүтэй шүгэл үлээдэг институцүүд бүр ажиллаж, татвар төлсөн байна, төлөөгүй байна, энэ ингэж татвараас зугтсан байна гэдэг нь ү хүртэл ил тод гаргаж ирж байж эндээс нь бүр ингээд мэргэжил ажил болгочихсон институцүүд байж байдаг юм. Одоо АНУ, Солонгосоос эхлээд байж байгаа. Бид хэд цаашдаа ингэж явах ёстой болов уу гэж би зүгээр бодож байгаа юм.

2 дугаарт 1 зүйл байгаа юм. Энэ компаниудын юм уу татвар төлөгчдийн асуудал ингээд зарлагдахгүй байхаар тэр компани дампуурч байгаа юм уу, санхүүгийн эрсдэлд орж байгаа юм уу, хэн ч мэддэггүй нөгөө харилцагчид бүх юм тэр компани бүр юу ч үгүй болсны дараа мэдээлэл ирдэг. Яагаад гэхээр тэр мэдээлэлтэй танилцах бололцоо байдаггүй. Ер нь зүгээр тодорхой хэмжээний энийг бас тодруулах ёстой юм байна. Тэрнээс биш үл ялиг зүйлүүдээр ингээд нийтэд мэдээлээд, доромжлоод байж болохгүй. Үнэхээр тодорхой хэмжээний бас харилцагчид нь нөлөөлж болохуйц ийм эрсдэлүүд энэ тэр байх юм бол мэдээлэхгүйгээс шалтгаалаад нөгөө оруулсан хөрөнгө оруулагчид нь эрсдээд дампуурлын хэрэг манайд яаж явдаг билээ энэ ерөөсөө бид хэд одоо цаашдаа дампуурлын эрх зүй явахаар олон мэдээлэл хуулийн этгээдийн хувьд татвар төлөгчийн хувьд ил тод болж байж энэ дампуурлын хэргүүд явдаг. Хувь хүний дампуурал ч гэсэн тэгж явдаг. Харин энэ мэдээллүүдийг нэгдсэн байдлаар тэр И-монголиа платформ, Улсын бүртгэл, татварын албуудыг нэгтгээд ер нь зүгээр ийм ийм компаниуд дээр дампуурлын хэрэг үүсгэсэн байгаа шүү. Ийм компаниудын санхүүгийн эрсдэлтэй холбоотой ийм мэдээлэл ил тод болж байгаа ч гэдэг юм уу нэгдсэн байдлаар бас жоохон ер нь бас тавимаар юм шиг байгаа юм.

Энэ мэдээлэл байхгүй учраас компаниуд дампуурсны дараа иргэний хэрэг дээр шүүх дээр гомдол гаргаад ирдэг байхгүй юу. Энэ чинь ингэчихсэн байна. Ийм юм боллоо гээд ийм л зүйлүүд болдог. Тэгэхээр энийг яах вэ зүгээр баланстай авч үзэх нь зөв байх. Цэцийн ярьж байгаа зүйлүүдийг бас дүгнээд хэрэвзээ хүлээж

авсан бол ямар хэмжээний өөрчлөлт оруулах вэ. Энийгээ бид хэд бас сайн бодмоор байгаа юм. 7 хоногийн дотор шуураад өнгөрөх биш. Түрүүн одоо нөгөө Золоо би хэлж байгаа. Цагдаа дээр хэн ч ойлголцоогүй шүү дээ. Тэгэхээр магадгүй Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ хувилбаруудаа сайн үзүүлэх, олон нийтэд мэдээллээ сайн өгч байгаад ингэж Цэцийн шийдвэрийг хүлээж аваад ингэж оруулах гэж байна гээд хэлэлцүүлэг бараг 1 удаа эвтэйхэн хэлэлцүүлэг хийчихдэг баймаар юм шиг байгаа юм. Тэгэхгүй бид хэд Хууль зүйн байнгын хороо шийдчихээр дараа нь тэр нь бүгд ..../минут дуусав/

**Д.Ганбат:** Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Би Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 тоот дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж авах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. Энэ бол ганцхан татварын хууль тогтоомжтой холбоотой Үндсэн хуулийн цэцийн шийдвэр биш байна гэж харж байна. Татварын хууль тогтоомжтой холбоотой Үндсэн хууль зөрчсөн гэх маргааныг хянан шийдвэрлэх хүрээнд Үндсэн хуулийн цэцээс гаргасан энэ шийдвэрийн үндэслэл хэсэг бол Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрхийн, тэр дотроо хүний хувийн халдашгүй эрхийг ямар хүрээнд ойлгох, ямар үндэслэл журмаар хязгаарлаж болох, хуулийн хэрэгжилтийн хүрээнд үүнийг хэрхэн ойлгох гэсэн суурь асуудлуудыг Үндсэн хуулийн цэц хэрэг дээрээ Үндсэн хуулийг тайлбарлах замаар энэхүү шийдвэрээ гаргасан байна гэж үзэж байна. Зөвхөн үндэслэл хэсэг гэхэд бол бараг 20 гаруй хуудас онолын судалгаа хийгдсэн байна.

Тухайлбал Цэцийн дүгнэлтийн 24 дэх хуудсанд хүний нэр төр нь хүн болохын хувьд угаас чухал үнэ цэнтэй гэж хүлээн зөвшөөрч, хүндэтгэх үүргийг төрд хүлээлгэж, хүн эрх зүйн этгээд байхыг хамгаалдаг. Иймээс Үндсэн хуулийн агуулгад нийцүүлэн dignity-нэр төр honor of reputation гэснийг алдар хүнд гэж томъёолж хэвших нь зүйтэй.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтаар баталгаажсан хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрх нь туйлын эрх биш тул Үндсэн хуулийн дагуу хязгаарлагдаж болно. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх болон шударга ёсны зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хуульд тодорхой заасан байх, тохирсон байх, шүүхийн хяналтад байх зэрэг зарчмыг хангах шаардлагатай бөгөөд эдгээр зарчмын аль нэгийг нь хангаагүй бол тухайн хязгаарлалт үндсэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл болно.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад хуульд заасан үндэслэл журмаас гадуур эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж заасан. Энэ заалтын дагуу эрх чөлөөнд тавих хязгаарлалт нь хуульд заасан үндэслэл журамтай байх төдийгүй, дур мэдсэн байж болохгүй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур эрх чөлөөг хязгаарлах нь дур мэдсэнд тооцогдоно. Түүнчлэн хуулиар зөвшөөрөгдсөн хязгаарлалт ч дур мэдсэн шинжтэй байж болно. Дур мэднэ гэх ойлголт нь зөвхөн хууль зөрчсөн гэсэн ойлголтоор хязгаарлагдахгүй, харин шударга бус, урьдчилан таамаглах боломжгүй, зохих журмыг баримтлаагүй, үндэслэлгүй, тохирсон бус гэх зэрэг илүү өргөн хүрээнд тайлбарлагдах бөгөөд нийтийн албан тушаалтны дур мэдэл үзэмжээс ангид байх гэсэн утгатай гэх мэтээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан, 2 дугаар бүлэгт заасан хүний эрхийн суурь үзэл баримтлалыг хууль тогтоогч болон гүйцэтгэх эрх мэдэл хэрхэн цаашид ойлгож энэ хүний үндсэн эрхүүдийг хязгаарлалт тавих вэ гэдэг дээр цаашид жишиг болохуйц шийдвэр гаргасан байна.



Тийм ч учраас би энийг хэлж байгаа юм. Энийг хууль боловсруулагч, хууль санаачлагч 3 институц Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар тэр дотроо Хууль зүй, дотоод хэргийн яам, хуулийг хэрэглэгч шүүх, хуулийг хэрэгжүүлэгч гүйцэтгэх эрх мэдлийн бүх байгууллагуудад энэ шийдвэрийг албан ёсоор дэлгэрэнгүй сурталчлах хэрэгтэй байна.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр гишүүний үг. Би дараа үг хэлэхдээ энэ дээр хэлнэ. Их чухал санаа хэлээд байна. Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Энэ цэцийн дүгнэлтийг дэмжиж байна. 1 дүгээр зүйлийг нь.

2 дугаар зүйл дээр нэг ийм байх юм. Энэ гомдол гаргасан хүмүүсийн асуудал нь бол татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр гээд хэдэн заалт байгаа юм. Энийг болохоор Үндсэн хууль зөрчөөгүй байна гээд хэлчхэж. 2, 3 аж ахуй эрхлэгч надад ирүүлсэн ийм асуулт байдаг юм. Би асууж чадахгүй яваад байсан юм. Та нар нэг хэлээд өгөөч. Эзэн нь мэдээгүй байхад банканд байсан данснаас нь банк руу бичиг өгөөд тэгээд татварын төлбөр, өр төлбөрийг барагдуулчихсан байгаа. Энийг би бол бас ойлгохгүй. Өөрийнхөө хэмжээнд болохгүй байх гээд л хэлчихсэн юм л даа. Тэгэхээр хуулиараа бол ингэдэг гээд байх юм. Яг хуулиараа ингээд хүний банканд байгаа данснаас жишээ нь НӨАТ-ын татвар хугацаандаа төлсөнгүй гэдэг юм уу тэгж хэлээд эзэнд нь хэлэхгүйгээр шууд данснаас нь банк нь гаргаад өгчхөж байгаа байхгүй юу. Тэр банкиг шаардаад байгаа этгээд нь татварын алба байгаа. Энд та нар нэг хариулт өгчхөөч. Тэр асуулт тавиад байсан хүмүүс нь ч гэсэн сонсоод, нэг ойлголт өгчихмөөр байх юм. Татварынхантай уулзсан дээрээ.

**Д.Цогтбаатар:** 4 дүгээр микрофон.

**Ц.Тогосмаа:** Татварын ерөнхий газар Тогосмаа. Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Татварын хуульд заасан татвар төлөгчийн үүргийн биелэлттэй холбоотойгоор татварын хууль тогтоомжоор ноогдуулсан, тайлагнасан татварыг бол хуулийн хугацаанд төлөх бол үүрэгтэй байдаг. Энэ үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор татварын өр үүсэх хуулийн үндэслэл бий болдог. Татварын өрийг хураах чиглэлээр бол хууль татварын ерөнхий хуульд бол тусгайлан хуульчилж өгсөн. Энэ дээр бол татвар төлөгчид мэдэгдэхгүйгээр банканд дахь мөнгийг нь татах гэдэг ийм юу асуудал бол байхгүй. Хамгийн түрүүнд бол татварын өрийг хураан барагдуулахтай холбоотойгоор Татварын ерөнхий хуульд заасны дагуу татвар төлөгчид нэхэмжлэх хүргүүлж байгаа. Энэ нэхэмжлэх дээр бол ийм одоо төгрөгийн өртэй байна. 10 өдрийн дотор та өрөө барагдуулна уу гэсэн үндсэндээ мэдээлэх зорилготой нэхэмжлэх хүргүүлж байгаа.

Дараа нь бол бид үл маргах журмаар дансны битүүмжлэлийг хийх талаар татвар төлөгч болон харьцаж байгаа банканд нь бол мэдээллийг бол хүргүүлэх ийм ажиллагааг бол хийдэг. Тэгэхээр татвар төлөгч бол энийг мэдэхгүй байх үндэслэл бол байхгүй. Яг процессоороо хийгддэг гэсэн үг. Тэгэхээр аль ч тал дээрээ үл маргах журмаар данснаас нь мөнгийг гаргуулах тохиолдолд ч татвар төлөгч мэдэж л байгаа.

**Д.Цогтбаатар:** Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

**С.Эрдэнэболд:** Би бусад Улсын Их Хурлын гишүүдийн асуулт саналтай давхцахгүйгээр ерөнхий зарчмын татвартай холбоотой зүйлүүдийг бас хэлэх гэсэн юм.

Нэгд нь болохоор Монгол Улсын одоо бид нар чинь баяр наадмаар 2 мянга илүү жилийн төрт ёсны түүхтэй улс гэж өөрсдийгөө тодорхойлдог. Тэгээд тэр Тониковкийн гэрэлт хөшөө, Гелтгений хөшөө дээр байгаа бичээс дээр бас байдаг. Толгойтныг бөхийлгөж, тойгтныг сөхрүүлж явсан аугаа их үндэстэн авлигад идэгдэж татварын буруу бодлогыг татвар нь ихсээд, тэгээд нуран унасан гэдэг ийм тэмдэглэл байдаг. Ер нь бол хүн төрөлхтний хөгжлийн зүй тогтол дээр энэ улс орнуудын хүн доройтохын нэг том шалтгаан бол энэ татварын буруу бодлого явдаг. 1982 оноос өгсүүлээд forum of small states гээд НҮБ-ын дэргэдэх 10-аас доош сая хүн амтай улс орнуудын зөвлөл байгаа. 37, 38 оронд идэвхтэй байгаа. Энд бол Монгол Улс гишүүнээр нэгдэж орсон байгаа.

Тэгэхээр 10-аас доош сая хүн амтай улс орнуудын ер нь хурдтай хөгжлийн гол түлхүүр юу юм бэ гэхээр 1 дүгээрт боловсролын маш зөв бодлого, 2 дугаарт бизнесийн орчин, тэр дундаа татварын бодлого гэж ингэж тодорхойлсон байгаа. Тэгэхээр энэ forum of small states гаргаж байгаа зөвлөмжүүдийг бас та бүхнийг хардаг байх гэж бодож байна. Тэгээд энэ зүйл маань сүүлийн 2016 оноос хойш ялангуяа нэлээн алдагдсан гэж би зүгээр харж байгаа юм. Яагаад гэхээр сонгууль болгоны өмнө аливаа улс төрийн намууд татвар нэмэхгүй гэж амладаг. Сонгуулийн дараа амтай юм шиг нэмдэг. Тэгээд 7 төрлийн татвар, хүүхдийн мөнгөний татвар эд нар гээд иргэдийн бухимдал төрүүлсэн маш олон асуудлууд байдаг. Тийм учраас энэ дээр бас бид нар цаашдаа анхаармаар байна.

2 дугаарт нь болохоор сая 10 сард БНСУ-д ажлаар явж байгаад тэнд бизнес эрхэлдэг монголчуудтай ярьж байхад тэнд зөвхөн нэг боомтоос өдөртөө 80 чингэлгийг Монгол Улс руу ачуулдаг. Солонгосын замдаа дайран өнгөрч байгаа Тяньжинь Хятадын татварын албууд бол маш зөв. Бид нарт тусалж ажилладаг. Ялангуяа яах вэ гэж хэлэлцүүлэг, хэлэлцээ гэх юм уу negotiation гэхээр чинь тийм байдлаар татвар тогтоохдоо тухайн хүний бизнесийнх нь зүй тогтол, ач холбогдлыг нь харж байгаад ингээд зөөлөн боломжууд олгож явдаг. Гэтэл Монгол Улсад ийм юм байдаггүй. Бусад улсуудын жишээг харахад бол татвартайгаа хамтран ажилладаг байхад Монгол Улсад бол татвараас айдаг, бизнес эрхлэгчид айдаг гэсэн зүйл яриад байдаг.

Дараагийн нэг зүйл нь сая Гадаад харилцааны яам дээрээс 210 мянган Монгол хүн хилийн чанадад ажиллаж амьдарч байгаагаас 50 мянга нь хууль бус байна гэж. Сүүлийн жилүүдэд бол гадагшаагаа явах залуучуудын брэнд байна гэж хэлдэг хүний тархины гоожилт маш хүчтэй болж байгаа. Эд нарын нэг шалтгаан нь бол Монгол улсад бизнес эрхлэхэд таагүй байна гэдэг шалтгаануудыг маш их ярьж байгаа. Энэ бизнес эрхлэхэд таагүй байгаа зүйлийн 1 нь өөрөө энэ татварын одоо нийцтэй биш бодлого байна гэж маш олон хүмүүс ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн бас анхаараарай гэж хэлмээр байна. Хамгийн энгийн жишээ бол одоо тэр Дубай ч гэдэг юм уу энэ хөгжиж байгаа орон Скандинавын орнуудын энэ татварын бодлогууд яаж иргэн рүүгээ чиглэсэн нөгөө бид нарын одоо яриад байгаа хүн төвтэй бодлого буюу эдийн засгийн хүн төвтэй орчныг эрх зүйн орчныг яаж бүрдүүлэх вэ гэдэг зүйлүүд их амжилттай яригдаад байгаа. Тийм учраас бас энэ татварын байгууллагын дарга нь байж байна, Сангийн яамны Татвар хариуцсан дарга нь байж байна. Энэ чиглэл дээр та бүхэн маань бас бодож

болгож яваач ээ. Дээрээс нь энэ Улсын Их Хурлаас сая бид нар 2024-2028 оны стратегийг тодорхойлсон байж байгаа. Дээрээс нь болохоор энэ төсвийг бол бүгд ярьдаг ч гэсэн төсвийг дагуулж орж ирж байгаа хөгжлийн хөтөлбөр дээр тэр болгон хэлэлцүүлэг их хүчтэй өрнөөгүй байгаа. Энэ дээрээ ч гэсэн энэ татварынхаа зүй зохистой бодлого тал дээр та бүхэн бас харгалзан үзэж байгаа гэж хүсмээр байна. Ингээд баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Заяабал гишүүний микрофоныг өгье.

**Б.Заяабал:** Гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг айлтгая. Өнөөдрийн энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэдэг ийм саналаар би бас үг хэлэх гэж байгаа юм. Өнөөдрийн энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдагдсан, иргэдээс ирсэн мэдээлэл, гомдлын дагуу хянан хэлэлцэхэд ийм 2 гол заалтыг авч үзсэн байгаа.

1 дүгээрт нь энэ Татварын ерөнхий хууль дээр байдаг 13.4-д байгаа татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хуулийн хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлөө 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эсвэл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэдэг энэ заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм дүгнэлтийг оруулж ирсэн байгаа юм. Тэгэхдээ яг энэ тодорхойлолтыг Үндсэн хуулийн дүгнэлтийг уншаад үзэх юм бол агуулгын хувьд бол энийг бол зөв байна гэж үзсэн. Зүгээр энийг бол тодорхойлж, тодорхой нарийн тусгах шаардлагатай гэсэн ийм агуулгаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан байгаа гэдгийг 1 дүгээрт бас гишүүдэд хэлье.

Энэ агуулгаар нь бас энийг илүү тодорхой болгох үүднээс Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авч энэ хуулийн зүйл заалтад бас тодорхой хуулийн дагуу энэ чинь ажлын 15 хоногийн дотор бас нэмэлт, өөрчлөлтийг оруулж батлуулах бас ийм хуулийн зохицуулалттай. Тэр дагуу бас энийг илүү тодорхой болгож, зохицуулах ийм шаардлага байна гэдэг ийм дүгнэлтийг бол би бол хүлээн зөвшөөрч байгаа юм.

2 дахь асуудал нь тэгэхдээ 1 дүгээр энэ асуудлын хүрээнд бол Татварын алба ер нь яг энэ хуулийг зөрчиж байсан юм уу гэдэг дээр би бас мэдээлэл өгөх нь зөв байх гэж ингэж бодож байна. Өнгөрсөн хугацаанд бол татварын алба яг энэ хуулийн зүйл заалтыг хэрэглэхдээ бусад татвар төлөгчдөд эрх ашгийг нь хохироох эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуйн нэгжүүдэд өөрөөр хэлбэл нэмэгдсэн өртгийн албан татварын хий бичилт бичдэг, татварын хуулийг зөрчдөг. Энэ нь эргээд бусад татвар төлөгч бизнесийн харилцаанд орж байгаа татвар төлөгчдөд татварын эрсдэлд оруулахаас хамгаалах үүднээс ийм хууль бус үйлдэл хийдэг татвар төлөгчдийг олон нийтэд мэдээлэх чиглэлээр татварынхан эрсдэлээс хамгаалах үүднээс бол татварын алба бол хэрэглэж ирсэн ийм заалт байгаа. Өртэй ч гэдэг юм уу. Зөрчил гаргасан энэ татвар төлөгчдийн мэдээллийг олон нийтэд бол өнгөрсөн хугацаанд бас хуулийн бас ийм тодорхойгүй байдлаас үүдэлтэйгээр бас энэ олон нийтэд бол тодорхой мэдээллийг өгч ажиллаж яваагүй гэдгийг бол 1 дүгээрт бас мэдээлэл болгож хэлье.

2 дугаарт энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт дээр дурдагдсан нэг заалт бол арилжааны банкнуудаас татвар төлөгчтэй холбоотой мэдээллийг гаргуулан

авдагтай холбоотой асуудал нь бас Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй байна гэдэг ийм гомдол, мэдээллийг өгсөн. Энийг Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцээд энэ нь бол Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн ийм дүгнэлтийг оруулж ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ дээр би бас нэг тайлбар хэлэхийг бас хүсээд байгаа юм. Энэ нь бол Татварын алба бол татварын алба, төрийн албан хаагч субъектив хамаарлаас ангид байхын тулд татварын алба нэгдсэн ийм мэдээллийн санг бүрдүүлж ажиллаж байгаа. Энэ дээрээ татвар төлөгчтэй холбоотой бүх төрлийн мэдээллүүдийг холбогдох бүх байгууллагуудаас гаргуулан авах энэ хуулийг бол энэ татварын хуульд зохицуулж оруулж ирж өгсөн байдаг. Энэ зохицуулалтын үр дүнд татвар төлөгч татвараа татварынхаа хуулийг биелүүлэхгүй байгаа, тайлангаа гаргаж чадахгүй байгаа, тайлангаа санаатай болон санамсаргүй гаргахгүй байгаа энэ үйлдэл мэдээллийг систем өөрөө мэдээллийн системдээ энэ мэдээллүүдийг агуулаад, энэ систем өөрөө тайлангийн боловсруулалтыг хийж, татвар төлөгч рүү урьдчилж дараагийн шатын татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх үүднээс татварын мэдээлэл болгож систем энэ мэдээллийг бол авч ашигладаг байгаа. Өнөөдөр энэ татварын хуулиар бол татвар төлөгч өөрөө сайн дураар орлогоо .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Гүйцээж хэлэх үү. Микрофон өгье.

**Б.Заяабал:** Орлогоо татвар төлөгч өөрөө мэдээлж, татварын албанд тайлан гаргаж хүргүүлэх ийм хуулийн зохицуулалт явдаг. Хуулийн зохицуулалт явдаг. Өнөөдөр бид нар мэдэж байгаа зах худалдааны төв дээр бизнес эрхэлж байгаа ченжүүд гэх мэтчилэн бид нар бол зөндөө асуудлуудыг олон нийтэд ярьдаг. Тэгэхдээ эдгээр иргэдийн хувьд бол тайлангаа гаргахтай холбоотой мэдлэг мэдээлэл дутмаг байгаа учраас татварын алба энд нь зайлшгүй мэргэжлийн нягтлан бодогч авах шаардлагагүйгээр төрийн байгууллагууд дээр байгаа мэдээллүүдийг татварын систем өөрөө мэдээллээ агуулаад, энэ мэдээлэл дээр нь үндэслээд татвар төлөгчид тайланг нь амар хялбар гаргаж өөрт нь мэдээлэх үүднээс татвар төлөгч өөрөө тэр тайлангаа өөрөө хянаад үнэн зөв байвал илгээх товч дарах энэ хэлбэрээр татварын төрийн үйл ажиллагааг хялбар болгох үүднээс энэ хөндлөнгийн мэдээллийг бол ашигладаг болсон гэдгийг бас мэдээлэл болгож өгье.

Хуулийн этгээдтэй холбоотой өнөөдөр Монголд 350 мянган хуулийн этгээд байгаа. Жилдээ 20-30 .../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** 1 удаа өгөх дэгтэй байгаа. Ганбат гишүүний микрофоныг өгье. Түрүүн Ганбат гишүүн орох гээд орохгүй байна гэж байсан юм.

**Д.Ганбат:** Ер нь ийм байна. Энэ хуулийг чинь ерөөсөө л ард түмэн л биелүүлдэг. Иргэд л биелүүлдэг. Аж ахуйн нэгжүүд. Бусад нь хамаагүй юм шиг иймэрхүү байдал газар их авч байна. Нэгэнт татвар тайлан баланстай холбоотой зүйл ярьж байгаа болохоор бас хэд хэдэн зүйлийг бас хэлчихье гэж бодож байна. Энэ Эрдэнэс Тавантолгой гээд л компани байна. Компани ч юм уу, юу ч юм бүү мэд. Ямар ч аж ахуйн нэгжид ордог юм, оролцдог юм. Байхгүй. Тэгээд өчигдөрхөн л бас уг нь тэр компанийн хувьцаа эзэмшигчид бүгдээрээ л байгаа байх Монгол Улсын иргэд. Гэтэл тэгээд тайлан баланс нь гарчихсан юм уу. 2024 оны ноогдол ашгийг шууд тарааж байна гээд л ингээд л тарааж байх юм. Бусад аж ахуйн нэгжүүд чинь бүгдээрээ л тайлан балансаа он гаргаад, санхүүгийн жил нь дууссаны дараа гаргадаг байх гэх мэтчилний ийм юмнууд байна. Тэгээд дуртай

үедээ дураараа гарч ирээд л хэдэн хүн. Ноогдол ашгийг нь тэгж тарааж байна, ингэж тарааж байна гээд л ингээд явчихдаг. Тэгтэл одоо хар л даа. Цахилгааны үнийг нэмчихсэн, тэгээд айл болгон л бараг өдөрт 1-2 цаг харанхуй байдаг. Энэ чинь одоо 21 дүгээр 2025 он шүү дээ. Нэг ийм байдалтай хариуцлагагүй юмнууд их байна. Тэгэхээр энэ хуулийг хаана, хаанаа биелүүлж мөрдөж ингэж ажилладаг баймаар байна.

Тэгээд тэр Цэцийн дүгнэлт энэ тэрийг бол Цэц нь л өөрөө л тайлбарладаг байх л даа. Хууль номоороо. Дүгнэлтийг нь бид нар мэдээж хэрэг уншаад хүлээж авах, авахгүйгээ шийдээд явдаг. Энэ дээр бол маш сайн дүгнэлт гарсан байна. Иргэд ч гэсэн бас өөрийнхөө тэр мэдээллийг хэн дуртай нь гаргаад ингээд явуулдаггүй гэдгээ ойлгож авсан байх. Үүнээс гадна бол энэ бүртгэл энэ тэр юм бол хачин болсон шүү дээ. Ерөөсөө л хэн дуртай нь тэр нотариатаар янз янз бүрийн бичиг хийлгэж аваад л хүний өмч хөрөнгийг хоорондоо шилжүүлээд авч болдог болчихсон. Хэд хэдэн өргөдөл гомдол нь бол над дээр ирж байсан.

Тэгэхээр энэ Татварын алба, тэр бүртгэлийн газартайгаа тэр юмаа байнга нийлүүлж, нэгтгэж явахгүй бол бас болохгүй юм билээ. Энэ талаар бас анхаарна биз гэсэн ийм зүйлийг та бүхэнд хэлье.

**Д.Цогтбаатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Би цөөн хэдэн зүйл хэлье. Энэ дээр нэг ийм юу. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн нэг онцлог байгаа юм. Энэ олон нийтэд мэдээлэх эрх байхгүй гэж хэлээгүй байгаа шүү дээ. Үүний чинь онцлог нь юу байна гэхээр мэдээлдэг журам тогтолцоо чинь өөрөө үзэмжийн шинж чанартай, гүйцэд боловсронгуй болоогүй байна л гэдгийг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ дээрээ цаашдаа анхаарч, энэ холбогдох байгууллагууд энийгээ нарийвчилж боловсронгуй болгож авч орж ирэхгүй бол болохгүй. Түүнээс бол түрүүн гишүүдийн бас хэлээд байгаа нөгөө залилчих вий, өөр иргэдийг хуурчих вий, мэдээлэл дутуугаас болоод зүгээр байгаа компани шиг дүр эсгэж байгаад хүмүүсийг хуурчих вий гэдэг тэр болгоомжлол бол хэнд ч байж байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ та нар маань их сайн бодох хэрэгтэй.

Яагаад гэвэл хүний эрх чөлөө гэдэг чинь нөгөө төрийн хувьд энэ дараа дараагийн тэр лүү халдах босгыг нь аль болох өндөрсгөж өгөх, энэ төрийн хувьд ийм үйлдлийг хийх аль болох хэцүү байх талаас нь л хуулийг бид нар тайлбарлаж ойлгох ёстой. Тэгээд үнэхээр аргагүй тохиолдолд яагаад ч болохгүй тохиолдолд л маш олон шалгуур биелсний дараа одоо уучлаарай өөрийн чинь хууль бол өөрийн чинь мэдээллийн аюулгүй байдлыг бол бүрэн хангаад, гэхдээ та бол яалт ч үгүй мэдээлэхгүй бол одоо энэ чинь нийгэмд хор хохирол учруулах нь гэдэг ийм шалгуурыг л өндөрсгөх тухай агуулгатай Үндсэн хуулийн тогтоол байгаа шүү. Тэгэхээр та нар энийгээ бодож үзэх хэрэгтэй байх.

Энд эрх зүйч гишүүддээ би нэг хуульч гишүүддээ хэдэн зүйл харин хэдүүлээ бас ярих хэрэгтэй юм байна. Жишээлбэл энэ ил тод байдал гээд байна шүү дээ. transparency гээд байгаа. Иргэн дээр төр мэдэх эрхтэй байхад өөрөөр хэлбэл зарим мэдээллийг төр зайлшгүй мэднэ шүү дээ. Төр мэдэх эрхтэй байна гэдэг бол ил тод байгаа асуудал шүү. Харин төр бол олон нийтэд бүх мэдээлэл нь ил тод байх ёстой. Тэгэхээр өөрөөр хэлбэл ил тод байна гэдэг иргэний хувьд бүх мэдээлэл нь олон нийтэд ингээд л гарч байдаг асуудал биш. Тийм учраас энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэр чинь та нарт босгыг нь өндөрсгөж өг. Та нар мэддэгээрээ мэддэг л юм байгаа байгаа биз. Тэгэхдээ олон нийтэд бол гаргахгүй

хуулиа хэрэгжүүлэх үүднээс мэддэг мэдээллээ та нар хадгалаад, хуулиа хэрэгжүүлэх гээд явах ёстой. Та нар тэр мэдээллийг чандлан хадгалж байх үүрэгтэй. Тэгээд болохгүй бол дараагийн шатын арга хэмжээгээ ав гэсэн. Өөрөөр хэлбэл ил тод байдал гэдэг бол иргэний хувьд төр мэддэг мэдээллээ мэдэж байхад л ил тод шүү. Түүнээс иргэний хувьд тэр хүний хувийн амьдралыг нийгэм тэр чигээрээ мэдээд байх асуудлыг ил тод гээд байгаа юм биш. Харин төрийн хувьд ил тод байдал гэдэг бол нийгэм тэр чигээрээ мэдэх ёстой юмаа мэдэж байх тухай асуудал. Энэ хоёрынхоо ялгааг бид нар бас хуулийн хэрэглээ дээрээ гаргаж бодож байх ёстой. Энэ дээр бас анхаарч ажиллах ёстой.

Тэгээд Хууль зүйн байнгын хороондоо хэдүүлээ бас эндээ яг ажиллаж энэ дээр ч гэсэн санаа бодлоо энэ хууль хэрэгжүүлж байгаа яг практик дээр хэрэгжүүлж байгаа байгууллагуудтайгаа ярих ёстой байх. Тэр хүрээнд Энхбаяр гишүүний саяын яриад байгаа энэ Үндсэн хуулийн цэцийн тогтоолтой холбогдуулаад бид нар зарим сургалт хийх ёстой юм биш биз дээ гэдгийг ч гэсэн Хууль зүйн яамтай үргэлжлүүлээд ярих ёстой юм байна гэж бодож байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулъя.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаа нь зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан татвар төлөгчийн талаар Татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 69,2 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан танилцуулна.

12.45 цаг.

**3 дахь асуудалдаа оръё. Эрүү шүүлт тулгах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Ингээд 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрхийн хэрэгжилт асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн баталсан.

Тогтоолын 2 дугаар хэсэгт эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахыг Хууль зүйн байнгын хороонд даалгасантай холбогдуулан тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөл дээр энэ сүүлийн ганц 2 бас нэмсэн өөрчлөлтүүд орчихсон байгаа. Та бүгдэд тараасан байгаа. Би ер нь тогтоолынхоо төслийг уншаад танилцуулчихъя.

Монгол Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, дугаар, Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13-д дах заалт, Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Хууль зүйн байнгын хорооны 2024 оны дугаар тогтоолыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч С.Эрдэнэболд Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд

Н.Алтанхуяг Улсын Их Хурлын гишүүн

Х.Баасанжаргал Улсын Их Хурлын гишүүн

Д.Ганбат Улсын Их Хурлын гишүүн

О.Номинчимэг Улсын Их Хурлын гишүүн

П.Сайнзориг Улсын Их Хурлын гишүүн

Х.Тэмүүжин Улсын Их Хурлын гишүүн

Г.Уянгахишиг Улсын Их Хурлын гишүүн

Н.Отгончимэг Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, мэдээлэл судалгаа гаргуулан дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг /С.Эрдэнэболд/-д зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн ийм тогтоолын төслийг танилцуулж байна. Үүнтэй холбогдуулан асуулт асуух гишүүд асуулт асууна уу. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Асуулт гэхээсээ илүүтэйгээр энэ тогтоолын төсөл дээр тогтоолын төслөөр байгуулагдаж байгаа ажлын хэсгийн ажлын хүрээ дээр жоохон юу байна. Зөвхөн эрүү шүүлт тул эрүү шүүлттэй холбоотой хохирогчийн эрхийг сэргээх болон хохирол барагдуулах чиглэлийн ийм ажил хийх юм уу, эсвэл үүнийгээ жоохон өргөтгөх юм уу. Би бол юу гэж хараад байна вэ гэхээр манайд одоо бол хохирол барагдуулах сангийн тухай зохицуулалттай нэг юм байгаад байгаа юм. Бусад улс орнуудад байгаа сайн туршлагыг нь харахаар хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай гээд процессын хууль байгаад байгаа юм. Тэгээд тэр процессын хуулиараа юу шийдэж байгаа вэ гэхээр энэ хохирол барагдуулж байгаа сангаас урьдчилж төлдөг зохицуулалтыг чухалчилж байгаа. Тэгээд ямар гэмт хэрэг дээр вэ гэхээр хүч хэрэглэсэн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэдэг тодорхойлолт гаргаж ирж байгаа. Хүч хэрэглэсэн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэдэг дотор нь эрүү шүүлт энэ тэр багтаж байгаа байхгүй юу. Одоо гудамжинд зүгээр явж байгаад нэг тавиргүй нөхөр ирээд хүний шүд цөм цохичхож байгаа байхгүй юу. Тэгээд эрүүл мэндээрээ хохирчихсон. Энэ эрүүл мэндийнхээ хохирлыг шийдүүлэхийн тулд тэр хүн тэр хүний гэмт хэрэгтэн мөн гэдгийг нотлох 3 шатны шүүхийг хүлээгээд 1 жил хагасаас 3 жил зогсож байгаа байхгүй юу ер нь бол. Гэтэл нөгөө улс орнууд чинь бол факт бол бодитой баримттай урьдчилаад тэр шүдтэй холбоотой, эрүүл мэндтэй холбоотой хохирлыг нь төлөөд, төр нөгөө хохироосон этгээдээс сангаа хохиролгүй болгохын тулд нөгөөдөх нэхэмжлэлээ нэхэмжлээд суучхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ нь юугаараа илүү чухал зарчим байна гэхээр нөгөө талени гэж ярьдаг шүдийг шүдээр гэдэг зарчим бол зэрлэг дундад зууны зарчим байна. Энийг арай соёлтой болгохын тулд хохирсон хүн хохирлоо нэхээд гуйгаад яваад байдаг биш. Яг энэ төрлийн гэмт хэргүүд дээр хохирогч нь өөрөө сэтгэл ханамжийнхаа хувьд бол хохирол барагдуулахынхаа хувьд бол ядаж 50-аас дээш 1 хувийн хүүтэй болж аваад тэгээд хохирогчийнхоо өмнөөс төр ажлаа хийдэг систем рүү явж байгаа. Тэгэхээр бид нар яг энэ боломжуудаа ашиглаад энэ ажлын хэсгээ яг тэр чиглэл рүү нь зориулаад жоохон өргөсгөөд та нар ер нь бол ингээд хохирол барагдуулах сантай холбоотой зохицуулалтаа илүү боловсронгуй болгох, процессжуулах, тэгээд хүч хэрэглэсэн энэ эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгтэй холбоотой асуудал дээр шинэ дэвшилтэт зохицуулалтын арга механизмыг оруулж ирэх энэ чиглэлээр ажилла гэж даалгавар өгөхгүй бол энэ өөрөө зөвхөн нэг хэрэг дээр.

Тэгээд би бол одоо бодитойгоор үр дагаврыг нь харж байна. Энэ ажлын хэсгийн хамгийн сүүлийн шийдэл нь Чимгээ, Содномдаржаа гэх мэт хүмүүст төсвөөс тэдэн төгрөг гаргаж өг гэдэг л шийдвэр болж хувирах байх гэж болгоомжилж байна. Ганцхан энд хүмүүсийн тухай асуудал биш, цаана нь байж байгаа гэмт хэргийн улмаас хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас эрх чөлөөгөөрөө хохирдог хүмүүс хохирсон дээрээ дахин дахин хохирдог шүүхийн систем дотор чирэгдэл дотор нь ингээд хохироод цаг хугацаагаа бардаг биш болоход л ажиллах тийм ажлын хэсэг байвал яасан юм бэ л гэдэг санал.

**Д.Цогтбаатар:** Санал гэж гишүүн ээ наадах чинь тэгэхээр тусдаа ажлын хэсэг байгуулах тухай. Энэ дотроо юу. Хийх ажлынхаа хүрээг өргөтгөх тухай л асуудал байна шүү дээ. Би бол дэмжиж байна. Тэртээ тэргүй энэ асуудлыг ажлын хэсэг Эрдэнэболд дарга удирдаад л явахаар алхам тутамд чинь 2 алхаад л энэ хохирлын асуудал өөрөө гарч ирнэ. Тэгээд ямар журмаар яаж шийдэгдээд байна гээд үүнээс сална гэж байхгүй. Энийг тэгээд хүрээнд нь оруулж ярьж л тодорхой шийдэхээс өөр үггүй. Тийм учраас миний хувьд бол би энийг дэмжиж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ч их өргөн байна шүү дээ. Тийм учраас ажлаа хувааж



байгаад л гишүүддээ хуваарилж өгч байгаад ажлаа дотоод зохион байгуулалтын л асуудал байгаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Би Тэмүүжин гишүүний саналыг дэмжиж байгаа. Эрүүгийн хуульд заасан ер нь олон гэмт хэргийн хохирогч байгаа. Эрүүгийн хуулийн зорилго гэж ярих юм бол 3 үндсэн зорилго дээр төвлөрдөг. Мэдээж цээрлүүлэх зорилго байгаа. Нөгөө талд зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирогчийн эрхийг сэргээх асуудал байдаг. 2015 оны Эрүүгийн хуулиас өмнөх 2002 оны хуулийг ярих гэж байна. Хуулийн хэрэгжилтийг авч үзэхэд 5 хохирогч тутмын 1 нь хохирлоо барагдуулжээ гэдэг ийм дүгнэлт 2016 онд хийсэн судалгаагаар гарч ирж байсан. 2015 оны Эрүүгийн хууль 2017 оны 7 сарын 1-ээс үйлчлээд 1 жил хагасын дараа хийгдсэн судалгаагаар буюу 2018 оны сүүлийн байдлаар 2015 оны Эрүүгийн хуулийн үр дүнд 5 хохирогчийн 3 нь хохирлоо барагдуулж байна гэдэг ийм статистик мэдээ гарсан юм. Тийм учраас энэ 2015 оны Эрүүгийн хүчин төгөлдөр хууль бол одоо миний хажууд байгаа Алтанхуяг Ерөнхий сайд, Тэмүүжин Хууль зүй, дотоод хэргийн сайд. Мөн энэ 2016 онд энэ Эрүүгийн хуулийн 49 хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон байгаа. Тэр үеийн Хууль зүйн сайд нь Бямбацогт. Миний хувьд бол дэд сайд байсан гэсэн үг.

Тэгэхээр энэ Ардчилсан нам, Монгол Ардын намын хамтын бүтээл гэж би бол энэ шинэ Эрүүгийн хуулийг бол дүгнэж явдаг. Хохирол барагдуулснаар хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэх хугацаанаас өмнө тэнсэх зэрэг хөшүүргүүдийг оруулж өгснөөр энэ хохирол барагдуулалт бол нэмэгдсэн байдаг. Тийм учраас энэ ажлын хэсгийг өргөн хүрээнд авч үзээсэй гэсэн ийм санал бодолтой байна.

Ер нь яах вэ энэ манай Их Хурал дээр одоогийн байдлаар 70-аад ажлын хэсэг гарчихсан явж байх шиг байна. Ер нь бол Ганбат ахаас бусад нь бараг бүгд ажлын хэсэг ахлагч нар болчих шиг боллоо. Би бол хэлээд байгаа шүү. Энэ их олон ажлын хэсэг гаргаж байгаа чинь хэрэг дээрээ парламентын Байнгын хороодын дотоод үйл ажиллагааг их тийм эвгүй байдалд оруулна гэдэг асуудлыг бол сануулаад байгаа. Ажлын хэсэг гарвал Байнгын хороодоосоо цаашаа энэ шиг гарч явбал энэ өөрөө их тийм мэргэшсэн байх тэр чиглэл хандлага руугаа илүү төвлөрдөг гэдгийг хэлье.

Тэгээд 2 дугаарт энэтэй ойролцоо бас ажлын хэсгийг манай Тэмүүжин гишүүн бас ахалж байгаа шүү дээ. Гэрч хохирогчийг хамгаалах тогтолцооны асуудлаар бас адилхан байхгүй юу. Тэгэхээр энэ ажлын хэсгүүдийн уялдааг хангах ажлын хэсэг бас манай Тамгын газар байгуулчихсан байна лээ. 10 хүнтэй. Энэ чинь нөгөө ажлын хэсгүүд нь уялдахгүй болоод ирсэн юм байна лээ шүү дээ.

**Д.Цогтбаатар:** Тэгье тэгье. Асуулт биш. Энэ бол үг байлаа гэж ойлголоо. Алтанхуяг гишүүн одоо үг хэлэх байхгүй юу. Тэгэхээр гишүүд ингээд асуулт асууж хариулт авч дууслаа. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

**Н.Алтанхуяг:** Энэ ажлын хэсэг байгуулахыг дэмжиж байгаа юм. Энхбаяр гишүүн, Тэмүүжин гишүүнтэй санал нэг байна. Жаахан өргөтгөмөөр байгаа юм. Энэ манай сонсгол дээр ирсэн хүмүүсийн чинь байна шүү дээ. Нэлээд нь бол

ингээд өөрийгөө хилс хэргээр ял авчихсан гэж байгаа хүмүүс байхгүй юу. Тэгээд тэд нар надад юу захиад байсан юм гэхээр 1 дүгээрт энэ ажлын хэсэгт өөрөө ор,

2 дугаарт энэ дээр ингэж байгаа юм жаахан өргөтгөмөөр байна. Асуудлынхаа хүрээг. Зөрчигдсэн эрхийг сэргээх гэхээр уг нь бид нар хэлмэгдчихсэн учраас бид нарын хэргийг сэргээмээр байдаг юм. Бид нар хэргээ сэргээлгэх гэхээр шинээр үүссэн нөхцөл байдал гэдэг нэг өгүүлбэр дээр очоод л хэрэг нь сэргэдэггүй. Тэгсэн мөртөө жишээ нь манай Гансүх гэхэд тэр гүйцэтгэх ажлын шугамаар олдсон мэдээллийг үндэслэж гээд шүүхийн шийдвэр цохичихсон. Гүйцэтгэх ажлын шугамаар олдсон мэдээлэл гэдэг нь хавтаст хэрэгт нь байдаггүй. Ийм ийм нөхцөл байдал байдаг юм. Би зүгээр тэмдэглүүлчхэж байгаа юм.

Тэгэхээр манай Эрдэнэболд дарга манай ажлын хэсэг дээр ийм жоохон өргөн хүрээтэй л юмнууд яригдах байх шүү гэж бодоод би энэ рүү орчхож байгаа. Энд үг үсгээр нь оролдоод яах вэ.

**Д.Цогтбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд үг хэлж дууслаа. Би энэ дээр бас ганц зүйл нэмээд хэлчихье. Эрдэнэболд гишүүн залуу хүний хувьд бол өөрөө олон хүний гомдол, зовлон хуримтлуулсан ийм асуудлыг өөрөө барьж авч байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр та зарчимтай, хуулиа бариад л зоригтой урагшаа явах ёстой. Гарч байгаа асуудлууд дээр бол яг хуулийнхаа хүрээнд асуултыг нь хайж өгч зарим юм чинь бол нээрээ ингээд шийдэхээргүй, үгүй ээ, энэ одоо яах юм бол гэмээр олон асуудал гарч ирнэ шүү. Тэгэхээр энэ дээр та нэлээн өөрөө манлайлал гаргаж, Монгол Улсад төр нь иргэнээ хохироочхоод зүв зүгээр тэр төр яваад байж болохгүй гэдэг л зарчмыг барьж ажиллах ёстой шүү. Тэгээд энэ дээр тэгэхлээр та өөрөө тэгж манлайлал идэвх гаргаж ажиллаарай л гэж би хэлмээр байгаа юм.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тэгээд энэ дээр санал хураалт явуулахаас өмнө энэ санал дотор Тэмүүжин гишүүний санал орсон байгаа шүү гэдгийг цохоод тэмдэглэе. Алтанхуяг гишүүний хэлсэн зүйлийг Эрдэнэболд дарга ажилдаа анхаарч ажиллах ёстой шүү. Тэгээд санал хураалт явуулъя. 69,2 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ талархал илэрхийлье. Энэ дээр гишүүддээ нэг зүйлийг хэлчихэд манай Байнгын хороо бол хуралдсан цагаараа хамгийн их хуралдсан, хамгийн их үр дүнтэй ажиллаж байгаа Байнгын хороо байна лээ шүү. Та бүгддээ бас талархал илэрхийлмээр байна.

13.00 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*